**Агуулга**


**Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал ......................3**

**I. Нийгмийн үзүүлэлт ..........................................................7**

1. Хүн ам ..........................................................................................7
2. Бүртгэлтэй ажилгүй иргэд ........................................................7
3. Нийгмийн эмзэг бүлэг ...............................................................9
4. Нийгмийн даатгал, халамж.......................................................10
5. Боловсрол ....................................................................................12
6. Эрүүл мэнд ..................................................................................14
7. Гэмт хэрэг .....................................................................................15

**II. Макро эдийн засгийн хандлага.........................................17**

1. Дотоодын нийт бүтээгдэхүүн ..................................................17
2. Үнэ ................................................................................................18
3. Мөнгө, зээл, үнэт цаас ..............................................................25
4. Улсын нэгдсэн төсөв..................................................................29
5. Гадаад худалдаа .........................................................................30

**III. Үйлдвэрлэл, үйлчилгээ .....................................................33**

1. Бизнес регистр ...........................................................................313
2. Мал аж ахуй ................................................................................34
3. Газар тариалан ...........................................................................36
4. Аж үйлдвэр .................................................................................37
5. Барилга ........................................................................................39
6. Дотоод худалдаа ........................................................................40
7. Тээвэр ..........................................................................................41
8. Шуудан, холбоо .........................................................................43
9. Хилээр нэвтэрсэн зорчигчид ....................................................43

**IV. Бусад ......................................................................................44**

1. Цаг уур, агаарын бохирдолт ....................................................44

**V. Хавсралт хүснэгтүүд ............................................................46**

**VI. Хөдөө аж ахуйн 2012 оны**
**тооллогын урьдчилсан дүн.................................................76**

**VII. Дэлхийн эдийн засаг, гадаад зах зээлийн тойм .............87**

**Дараах тэмдэглэлүүдийг ашиглав:**

| | |
|---|---|
| ... | **мэдээлэл байхгүй** |
| 0.0 | **маш бага тоо** |
| - | **гүйцэтгэл байхгүй** |
| * | **Урьдчилсан гүйцэтгэл** |

**Монгол Улсын нийгэм,**

**эдийн засгийн байдал**

(2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр)

## I. Нийгмийн үзүүлэлт

Монгол Улсын хүн амын тоо 2012 оны жилийн эцэст урьдчилсан дүнгээр 2869.5 мянга, үүнээс Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоо 2762.4 мянга болж, оны эхнээс 57.9 мянган хүн буюу 2.1 хувиар өслөө.

Улсын хэмжээнд 2012 онд 74474 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 74778 болж, өмнөх оныхоос амаржсан эхийн тоо 4146 эхээр буюу 5.9 хувь, хүүхдийн тоо 4202 хүүхдээр буюу 6.0 хувиар өссөн байна.

Улсын хэмжээгээр 2012 онд нялхсын эндэгдэл 1143 болж, өмнөх оныхоос 9 хүүхэд буюу 0.8 хувь, 1-5 хүртэлх насандаа 253 хүүхэд эндэж, өмнөх оныхоос 5 хүүхэд буюу 1.9 хувиар буурсан байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2012 оны 12 дугаар сарын эцэст 35.8 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 21.4 мян.хүн буюу 37.4 хувиар буурчээ.

Бүх шатны сургуульд суралцагчдын тоо 2012/2013 оны хичээлийн жилийн эхэнд 897.9 мян.хүн болж, өмнөх оныхоос 7.3 мян.хүн буюу 0.8 хувиар нэмэгдэв.

Бүх шатны сургуулийг 2011/2012 оны хичээлийн жилд 167.8 мянган суралцагчид төгссөнөөс ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийг 107.0 мянга (9-р ангийг 66.8 мянга, 11-р ангийг 38.6 мянга), мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-ийг 23.1 мянга, их, дээд сургууль, коллежийг 37.7 мянган оюутан төгсчээ.

Нийгмийн даатгалд 2012 онд 741.4 мян.хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 504.3 мянга буюу 68.0 хувь нь аж ахуйн нэгж байгууллагынх, 237.1 мянга буюу 32.0 хувь нь төсөвт байгууллагынх байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийт шимтгэл төлөгч, даатгуулагчдын тоо 87.9 мянга буюу 13.4 хувь, үүнээс аж ахуйн нэгж, байгууллагынх 75.3 мянга буюу 17.6 хувь, төсөвт байгууллагынх 12.6 мянга буюу 5.6 хувиар нэмэгджээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2012 онд 60.7 мян.хүн хамрагдсан нь өмнөх оныхоос 3.8 мян.хүн буюу 6.8 хувь, олгосон тэтгэврийн хэмжээ 29.3 тэрбум төг буюу 82.8 хувиар нэмэгджээ.

Халдварт өвчнөөр 2012 онд 43305 хүн өвчилж, өмнөх оныхоос 466 хүн буюу 1.1 хувиар нэмэгдсэн нь вирүст хепатитаар өвчлөгчдийн тоо 7816 хүн буюу 53.3 хувь, салхин цэцгээр 291 хүн буюу 9.4 хувь, цусан суулгаар 69 хүн буюу 3.3 хувь, сүрьеэгээр өвчлөгчдийн тоо 41 хүн буюу 1.0 хувиар буурсан хэдий ч гахайн хавдраар өвчлөгчдийн тоо 8044 хүн буюу 8.9 дахин, тэмбүүгээр 686 хүн буюу 16.1 хувь, трихомониазаар 158 хүн буюу 4.0 хувь, гонококкт халдвараар өвчлөгчдийн тоо 192 хүн буюу 3.7 хувиар өссөнөөс голлон шалтгаалав.

Улсын хэмжээнд 2012 онд 22089 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 2892 хэргээр буюу 15.1 хувиар өсчээ. Өмнөх оныхоос нийт гэмт хэргийн тоо нэмэгдэхэд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (1791), хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг (693), байгаль хамгаалах журмын эсрэг (140), тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг (129) зэрэг гэмт хэрэг өссөн нь голлон нөлөөлөв.

Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 8436 хүн гэмтэж, 901 хүн нас барсан нь өмнөх оныхоос гэмтсэн хүний тоо 336 буюу 4.1 хувиар өсч, нас барсан хүний тоо 21 буюу 2.3 хувиар буурсан байна.

## II. Макро эдийн засгийн үзүүлэлт

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ий хэмжээ 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 13944.2 тэрбум төгрөг, 2005 оны

зэрэгцүүлэх үнээр 5492.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос оны үнээр 2856.5 тэрбум төгрөг буюу 25.8 хувь, зэрэгцүүлэх үнээр 600.9 тэрбум төгрөг буюу 12.3 хувиар өслөө.

ДНБ-ий 2012 оны бодит өсөлтөд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 21.3 хувь, уул уурхай, олборлох салбарынх 8.9 хувь, тээврийн салбарынх 11.4 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний салбарынх 9.2 хувь өссөн нь голлон нөлөөллөө.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ий хэмжээ 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 14621.1 тэрбум төгрөг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 5509.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос оны үнээр 3452.9 тэрбум төгрөг буюу 30.9 хувь, зэрэгцүүлэх үнээр 598.6 тэрбум төгрөг буюу 12.2 хувиар өслөө. Энэ бодит өсөлтөд эцсийн хэрэглээ 18.1 хувь, нийт хуримтлал 24.0 хувиар өссөн нь голлон нөлөөллөө.

2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр тооцсон ДНБ-д эцсийн хэрэглээ 64.2 хувь, нийт хуримтлал 60.6 хувь, цэвэр экспорт -24.7 хувийг эзэлж, өмнөх оныхоос эцсийн хэрэглээ 1.9 пункт, цэвэр экспорт 0.4 пунктээр өсч, харин хөрөнгийн нийт хуримтлал 1.5 пунктээр буурсан байна.

Бүтцийн энэ өөрчлөлтөд 2012 онд эцсийн хэрэглээ өссөн нь голлон нөлөөллөө.

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮУИ) 2012 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 0.8 хувь, өмнөх оны эцсээс 14.0 хувиар өслөө. Инфляцийн жилийн дундаж түвшин 14.3 хувь байв. Ерөнхий индекс 2012 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 0.8 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.7 хувь, тээврийн бүлгийнх 1.1 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2012 оны 12 дугаар сарын эцэст 7617.2 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 584.0 тэрбум төг буюу 8.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 1204.9 тэрбум төг буюу 18.8 хувиар өсчээ.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2012 оны 12 дугаар сарын эцэст 828.5 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 106.4 тэрбум төг буюу 14.7 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 115.1 тэрбум төг буюу 16.1 хувиар өсчээ.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2012 оны 12 дугаар сарын эцэст 6990.5 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 122.7 тэрбум төг буюу 1.8 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 1349.3 тэрбум төг буюу 23.9 хувиар өсчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2012 оны 12 дугаар сарын эцэст 110.6 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 37.1 тэрбум төг буюу 25.1 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 36.9 тэрбум төг буюу 50.1 хувиар өсчээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2012 оны 12 дугаар сарын эцэст 295.1 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 3.4 тэрбум төг буюу 1.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 34.9 тэрбум төг буюу 10.6 хувиар буурсан байна.

Үнэт цаасны арилжаа 2012 оны 12 дугаар сард 20 өдөр явагдаж, 1.1 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 1.5 сая ш үнэт цаас арилжигдсан байна.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн нийт хэмжээ 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4880.9 тэрбум төг, зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 6043.9 тэрбум төгрөг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1163.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн урсгал орлого 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4840.8 тэрбум төг, урсгал зардал 4590.1 тэрбум төг болж, тэнцвэржүүлсэн урсгал тэнцэл 250.6 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.

Татварын нийт орлого өмнөх оныхоос 533.4 тэрбум төг буюу 14.5 хувиар нэмэгдэхэд гадаад худалдааны татварын орлого 10.1 тэрбум төг буюу 3.0 хувиар буурсан хэдий ч

нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 212.9 тэрбум төг буюу 45.0 хувь, дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого 198.8 тэрбум төг буюу 13.9 хувь, бусад татварын орлого 91.0 тэрбум төг буюу 15.9 хувь, орлогын албан татварын орлого 36.2 тэрбум төг буюу 4.3 хувь, өмчийн татварын орлого 4.5 тэрбум төг буюу 26.2 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Татварын бус орлого өмнөх оныхоос 93.7 тэрбум төг буюу 17.2 хувиар нэмэгдэхэд төсөвт газрын өөрийн орлого 41.8 тэрбум төг буюу 17.9 хувиар буурсан хэдий ч хувьцааны ногдол ашгийн орлого 66.8 тэрбум төг буюу 75.5 хувь, газрын тосны орлого 32.5 тэрбум төг буюу 42.8 хувь, хүү, торгуулийн орлого 20.7 тэрбум төг буюу 35.7 хувь, бусад нэр заагдаагүй орлого 11.9 тэрбум төг буюу 22.8 хувь, навигацын орлого 3.6 тэрбум төг буюу 10.2 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр 6043.9 тэрбум төг болж, өмнөх оныхоос 1046.9 тэрбум төг буюу 20.9 хувиар нэмэгдсэн нь эргэж төлөгдөх цэвэр зээл 410.4 тэрбум төг буюу 85.5 хувиар буурсан хэдий ч бараа, үйлчилгээний зардал 705.2 тэрбум төг буюу 46.9 хувь, татаас ба шилжүүлгийн зардал 559.4 тэрбум төг буюу 33.0 хувь, хөрөнгийн зардал 103.5 тэрбум төг буюу 8.1 хувь, зээлийн үйлчилгээний төлбөрийн зардал 89.1 тэрбум төг буюу 3.4 дахин өссөнөөс шалтгаалжээ.

Хөрөнгийн зардалд 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1384.4 тэрбум төг зарцуулсан нь өмнөх оныхоос 103.5 тэрбум төг буюу 8.1 хувиар нэмэгджээ. Энэ нь өмнөх оныхоос гадаадын эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн зардал 8.0 тэрбум төг буюу 4.7 хувиар буурч, дотоодын эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн зардал 111.5 тэрбум төг буюу 10.0 хувиар өссөнөөс шалтгаалсан байна.

Монгол Улс 2012 онд дэлхийн 146 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт урьдчилсан дүнгээр 11123.5 сая ам.долл, үүнээс экспорт 4384.6 сая ам.долл, импорт 6738.9 сая ам.долларт хүрчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2011 онд 1780.9 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ өмнөх оныхоос 1489.3 сая ам.долл буюу 6.1 дахин нэмэгдэж байсан бол 2012 оны урьдчилсан дүнгээр 2354.3 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оныхоос 573.4 сая ам.долл буюу 32.2 хувиар өсчээ.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оныхоос 292.4 сая ам.долл буюу 2.6 хувь, экспорт 432.9 сая ам.долл буюу 9.0 хувиар буурч, импорт 140.5 сая ам.долл буюу 2.1 хувиар нэмэгджээ.

Экспортын 98.6 хувийг эрдэс бүтээгдэхүүн, нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл, мал, амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн эзэлж байна.

## III. Эдийн засгийн салбарын үзүүлэлт

Улсын хэмжээгээр 2012 оны эцэст 40.9 сая толгой мал, үүний дотор 2330.4 мян.адуу, 2584.6 мян.үхэр, 305.8 мян.тэмээ, 18141.4 мян.хонь, 17558.7 мян.ямаа тоологдов.

Малын нийт тоо өмнөх оныхоос 4.6 сая буюу 12.6 хувиар өссөний дотор адуу 217.5 мянга буюу 10.3 хувь, үхэр 244.9 мянга буюу 10.5 хувь, тэмээ 25.8 мянга буюу 9.2 хувь, хонь 2.5 сая буюу 15.8 хувь, ямаа 1.6 сая буюу 10.2 хувиар өсчээ.

Оны эхэнд тоологдсон нийт малын 1.2 хувь буюу 0.4 сая том мал 2012 онд зүй бусаар хорогдов.

2012 онд 479.3 мян.т үр тариа, 245.9 мян.т төмс, 98.9 мян.т хүнсний ногоо хурааж, 1175.1 мян.т хадлан, 39.1 мян.т гар тэжээл бэлтгэсэн байна. Өмнөх оныхоос хураасан үр тариа 33.2 мян.т буюу 7.5 хувь, төмс 44.3 мян.т буюу 22.0 хувиар нэмэгдэж, харин хүнсний

ногоо 56.3 т буюу 0.1 хувь, хадлан 20.1 мян.т буюу 1.7 хувь, гар тэжээл 7.7 мян.т буюу 16.4 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2012 онд 2206.8 тэрбум төг болж, өмнөх оныхоос 147.8 тэрбум төг буюу 7.2 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд 35 хувийн агуулгад шилжүүлснээр зэсийн баяжмал, алт, цайрын баяжмал, төмрийн хүдэр, хайлуур жоншны баяжмал, газрын тос зэрэг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.1-42.6 хувь; хиаман төрлийн бүтээгдэхүүн, металл цувимал, сүлжмэл эдлэл, архи, нарийн боов, талх, хивс, гурил, цэвэр ус, малын тэжээл, цахилгааны утас, металл бэлдэц, шар айраг, шингэн сүү, зүсмэл материал, бетон зуурмаг, шавардлагын зуурмаг, шахмал түлш, бетон дэр зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.8 хувиас 3.9 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Барилга угсралт, их засварын ажил 2012 онд 811.3 тэрбум төг болж, 748.1 тэрбум төг буюу 92.2 хувь нь дотоодын, 63.2 тэрбум төг буюу 7.8 хувь нь гадаадын барилгын байгууллагуудад ногдож байна.

Барилга угсралт, их засварын ажил өмнөх оныхоос 66.3 тэрбум төг буюу 8.9 хувиар өсөхөд дотоодын байгууллагын гүйцэтгэсэн ажил 90.9 тэрбум төг буюу 13.8 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөллөө.

Бүх төрлийн тээврээр 2012 онд 53.3 сая т ачаа, давхардсан тоогоор 318.7 сая зорчигч зорчсон нь өмнөх оныхоос тээсэн ачаа 9.2 сая т буюу 21.0 хувь, зорчигчдын тоо 22.5 сая хүн буюу 7.6 хувиар нэмэгджээ.

Аюулт үзэгдэл, осол 2012 онд 4040 удаа гарсны улмаас 237 хүн амь насаа алдаж, 13.0 мянган толгой мал, амьтан хорогджээ. Объектын түймэр 3501 удаа, ой, хээрийн түймэр 229 удаа, гол, нуурын усанд хүн унасан осол 105 удаа, мал, амьтны халдварт галзуу өвчин 35 удаа, аадар бороо, үерийн үзэгдэл 34 удаа, бичил уурхай, нурангины осол 28 удаа, хүчтэй салхи, шуурга 26 удаа, аянгын үзэгдэл 19 удаа, малын халдварт боом өвчин, 3.5-аас дээш магнитудын газар хөдлөлт тус бүр 15 удаа, химийн хорт бодисын алдагдалтай холбоотой ослын дуудлага 11 удаа бүртгэгджээ. Аюулт үзэгдэл, ослын улмаас 94.5 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Өмнөх оныхоос аюулт үзэгдэл, ослын тохиолдол 492-оор, амь насаа алдсан хүний тоо 24-өөр нэмэгдэв.

Ус, цаг уурын хүрээлэнгийн мэдээгээр хамгийн их хур тунадас 2012 оны 12 дугаар сард Дорнод аймгийн Халхгол суманд орж 16.9 мм-т хүрчээ. Энэ оны 12 дугаар сард Говь-Алтай аймгийн Цогт суманд хамгийн их температур 4.0 хэм, Завхан аймгийн Цэцэн-Уул суманд хамгийн бага температур -50.0 хэм байлаа. Салхины хурд Баянхонгор аймгийн Шинэжинст, Өмнөговь аймгийн Манлай суманд 24 м/с хүрчээ.

Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2012 оны 12 дугаар сард Улаанбаатар хотын 32-ын тойрог, Хархорин захын орчимд тус бүр 29 удаа, Баруун дөрвөн замын орчимд 28 удаа, 13-р хороолол орчимд 26 удаа, Офицеруудын ордон, 1-р хороолол орчимд тус бүр 12 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж 32-ын тойрог, Офицеруудын ордон орчимд тус бүр 31 удаа, 13-р хороолол орчимд 30 удаа, 1-р хороолол орчимд 28 удаа, Хархорин захын орчимд 25 удаа Баруун дөрвөн замын орчимд 23 удаа, 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж 32-ын тойрог, Хархорин захын орчимд тус бүр 28 удаа, 13-р хороолол орчимд 27 удаа, Баруун дөрвөн замын орчимд 26 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Баруун дөрвөн замын орчимд 27 удаа агаарын чанарын стандарт дах хүлцэх хэм хэмжээнээс тус тус давсан байна.

# I. Нийгмийн үзүүлэлт

## I.1. Хүн ам

Монгол Улсын хүн амын тоо 2012 оны жилийн эцэст урьдчилсан дүнгээр 2869.5 мянга, үүнээс Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоо 2762.4 мянга болж, оны эхнээс 57.9 мянган хүн буюу 2.1 хувиар өслөө.

Эрүүл мэндийн яамны захиргааны статистикийн мэдээгээр 2012 онд 74.5 мянган эх амаржиж, 74.8 мянган хүүхэд мэндэлсэн байна. Амаржсан эхийн тоо 2012 онд өмнөх оныхоос 5.3 мянгаар буюу 7.7 хувиар нэмэгдэв. 1000 хүнд ногдох төрөлт 2012 оны жилийн эцсийн байдлаар 27.1, нас баралт 6.1, хүн амын ердийн цэвэр өсөлт 21.0 болов (Зураг I.1). Төрөлтийн түвшин 2012 онд нэмэгдэж, нас баралт буурснаас хамаарч, хүн амын ердийн цэвэр өсөлт 2.8 пунктээр өссөн байна.

1000 хүнд ногдох төрөлт 2012 онд Говьсүмбэр, Ховд, Баян-Өлгий, Орхон, Дархан-Уул, Увс, Баянхонгор, Хөвсгөл аймаг болон Улаанбаатаар хотод улсын дунджаас 0.1-4.4 пунктээр дээгүүр, Дорнод аймагт улсын дундаж түвшинд, бусад аймагт улсын дунджаас 1.6-13.9 пунктээр доогуур байна.

1000 хүнд ногдох нас баралт Хөвсгөл, Дорнод, Говьсүмбэр, Завхан, Өвөрхан-гай, Увс, Сүхбаатар, Дархан-Уул аймаг болон Улаанбаатар хотод улсын дунджаас 0.1-1.0 пунктээр дээгүүр, Дундговь, Хэнтий аймагт улсын дундаж түвшинд, бусад аймагт улсын дунджаас 0.1-1.5 пунктээр доогуур байна.

Хүн амын ердийн цэвэр өсөлт Ховд, Говьсүмбэр, Баян-Өлгий, Орхон, Дархан-Уул, Баянхонгор, Увс аймаг болон Улаанбаатар хотод улсын дунджаас 0.1-4.0 пунктээр дээгүүр, бусад аймагт улсын дунджаас 0.9-13.0 пунктээр доогуур байна.

Зураг-I.1

**Төрөлт, нас баралт, ердийн цэвэр өсөлт, 1000 хүнд ногдохоор, жил бүрийн эцсийн байдлаар**




*Эх үүсвэр: Эрүүл Мэндийн Яамны мэдээлэл*

Зураг-I.2

**Хөдөлмөрийн хэлтэст шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо, жилийн эцсийн байдлаар**




Зураг-I.3

**Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2012 оны 12 дугаар сарын эцэст**




## I.2 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2012 оны 12 дугаар сарын эцэст 35.8 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 21.4 мян. хүнээр буюу 37.4 хувиар буурчээ. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 18.8 мянга буюу 52.5 хувийг эмэгтэйчүүд эзэлж өмнөх оны мөн үеийнхээс 6.9 пунктээр өсчээ. Аймаг, нийслэлийн хөдөлмөрийн хэлтэст 2012 онд ажилгүй 61.5 мян.иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 35.3 мянган ажилгүй иргэн ажилд зуучлагдан орж, 10.6 мян.иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагджээ (Зураг I.2).

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 0.4 хувийг магистр, доктор, 27.6 хувийг нь дипломын болон бакалаврын, 5.6 хувийг тусгай мэргэжлийн дунд, 6.4 хувийг техникийн болон мэргэжлийн, 40.2 хувийг бүрэн дунд, 14.5 хувийг суурь, 4.2 хувийг бага боловсролтой, 1.1 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна (Зураг I.3).

Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 22.3 мянга буюу 62.2 хувь нь 15-34 насны залуучууд байгаа бөгөөд энэ үзүүлэлт Өвөрхангай, Говь-Алтай, Дорнод, Сүхбаатар, Өмнөговь, Говьсүмбэр, Архангай, Орхон аймгуудад улсын дунджаас 1.2-22.2 пунктээр их байна.

## Ажлын шинэ байр

Хөдөлмөрийн яамны мэдээгээр 2012 онд 54695 хүн ажлын шинэ байранд ажилд орсны 23637 буюу 43.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Ажлын шинэ байранд ажилд орсон ажиллагчдыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилбал 2.4 хувийг төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын, 3.1 хувийг тээвэр ба агуулахын үйл ажиллагааны, 3.2 хувийг боловсролын, 3.9 хувийг зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний, 8.7 хувийг уул уурхай, олборлолтын, 9.3 хувийг үйлчилгээний бусад үйл ажиллагааны,12.5 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 13.8 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн, 15.9 хувийг хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын, 20.1 хувийг барилгын, 7.1 хувийг бусад салбарын ажиллагчид эзэлж байна (Зураг I.4).

Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийн 11422 буюу 20.9 хувь нь 15-24 насны, 19469 буюу 35.6 хувь нь 25-34, 13244 буюу 24.2 хувь нь 35-44, 9871 буюу 18.0 хувь нь 45-59, 689 буюу 1.3 хувь нь 60 ба түүнээс дээш насны хүмүүс байна. (Зураг I.5).

Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийн 0.3 хувь нь зэвсэгт хүчний ажил мэргэжилтэй, 2.6 хувь нь контор, үйлчилгээний ажилтан, 2.9 хувь нь техникч болон туслах/дэд мэргэжилтэн, 3.4 хувь нь менежер, 5.5 хувь нь суурин төхөөрөмж, машин, механизмын операторч, угсрагч, 12.1 хувь нь мэргэжилтэн, 14.6 хувь нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан,16.4 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 19.3 хувь нь энгийн ажил мэргэжил, 22.9 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлалын холбогдох ажил үйлчилгээний мэргэжилтэй хүмүүс байна.

Зураг-I.4

**Ажлын шинэ байранд ажилд орсон иргэд, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2012 онд**




Зураг-I.5

**Ажлын шинэ байранд ажилд орсон иргэд, насны бүлгээр, дүнд харьцуулсан хувиар, 2012 онд**




## Гадаадын иргэд

Манай Улсад 2012 онд 102 орны 10.1 мян.иргэн хөдөлмөр эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 9 орноор нэмэгдэж, харин ажиллагчдын тоо 5.4 мян.иргэнээр буурчээ.

Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй нийт ажиллагчдын 38.6 хувь нь БНХАУ-ын, 16.9 хувь нь БНАСАУ-ын, 7.2 хувь нь ОХУ-ын, 5.0 хувь нь БНСУ-ын, 4.6 хувь нь БНСВУ-ын, 4.5 хувь нь АНУ-ын, 23.2 хувь нь бусад улсын харьяат иргэд байна. Өмнөх оны мөн үеийнхээс манай улсад хөдөлмөр эрхэлж буй БНСВУ-ын иргэдийн тоо 24.7 хувь, БНАСАУ-ын иргэдийн тоо 19.1 хувь, БНСУ-ынх 10.2 хувь, АНУ-ынх 1.3 хувь, бусад улсынх 4.5 хувиар өсч, харин БНХАУ-ынх 60.3 хувь, ОХУ-ынх 7.2 хувиар буурчээ.

Манай Улсад хөдөлмөр эрхэлж буй гадаадын 2116 иргэд буюу 21.0 хувь нь барилгын, 1907 хүн буюу 19.0 хувь нь уул уурхай, олборлолтын, 1506 хүн буюу 15.0 хувь нь тээвэр ба агуулахын үйл ажиллагааны, 1096 хүн буюу 10.9 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 1075 хүн буюу 10.7 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн, 927 хүн буюу 9.2 хувь нь боловсролын, 1433 хүн буюу 14.2 хувь нь бусад салбарт ажиллаж байна (Зураг I.6).

Зураг-I.6

**Гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2012 оны жилийн эцсийн байдлаар**




## I.3 Нийгмийн эмзэг бүлэг

Улсын хэмжээгээр өнчин хүүхдийн тоо 2012 онд нийт 40.4 мянга болсны, 4.3 мянга буюу 10.6 хувь нь бүтэн өнчин, 36.1 мянга буюу 89.4 хувь нь хагас өнчин хүүхдүүд байна. Сүүлийн жилүүдэд өнчин хүүхдийн тоо буурч байгаа бөгөөд бүтэн өнчин хүүхдийн тоо 2012 онд өмнөх оныхоос 23 хүүхдээр буюу 0.5 хувиар, хагас өнчин хүүхдийн тоо 402 хүүхэд буюу 1.1 хувиар багасчээ (Зураг III.16).

Нийт өнчин хүүхдийн 5.7 мянга буюу 14.2 хувь нь 0-6 насны, 7.4 мянга буюу 18.3 хувь нь 7-9 насны, 16.9 мянга буюу 41.9 хувь нь 10-15 насны, 10.4 мянга буюу 25.6 хувь нь 16-18 насны хүүхдүүд байна.

Зам тээврийн болон ахуйн осолд өртсөн хүүхдийн тоо 2012 онд 64 болж, өмнөх оныхоос 16 хүүхдээр, халдварт өвчин, тахалд нэрвэгдсэн хүүхдийн тоо 32 болж, 86 хүүхдээр, амиа хорлох оролдлого хийсэн хүүхдийн тоо 2 болж 1 хүүхдээр буурав. Харин байгалийн гамшигт өртсөн хүүхдийн тоо 13 болж, 7 хүүхдээр нэмэгдсэн бөгөөд тэдгээрийн нийт дүнд 0-6 насны хүүхдийн эзлэх хувь өмнөх оныхоос 19.2 пунктээр, 16-18 насны хүүхдийнх 7.7 пунктээр нэмэгдэв. Харин 7-9 насны хүүхдийнх 25.6 пунктээр,10-15 насны хүүхдийнх 1.3 пунктээр буурчээ.

Зураг-I.7

**Бүтэн, хагас өнчин хүүхдийн тоо жил бүрийн эцсийн байдлаар**




Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо 2012 онд 81.6 мянга болж, өмнөх оныхоос 23 хүн буюу 0.03 хувиар өсч, өрх толгойлсон эрэгтэйчүүдийн тоо 30.1 мянга болж, өмнөх оныхоос 710 хүн буюу 2.4 хувиар нэмэгджээ. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоог өмнөх 3 жилийн дундажтай харьцуулахад 277 хүн буюу 0.3 хувиар нэмэгджээ.

Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн 47.5 мянга буюу 58.2 хувь нь 3 хүртэлх, 27.1 мянга буюу 33.3 хувь нь 3-5, 7.0 мянга буюу 8.5 хувь нь 6, түүнээс дээш ам бүлтэй байна (Зураг I.7). Өрх толгойлсон эрэгтэйчүүд 30.1 мянга болж, тэдний 19.5 мянга буюу 64.9 хувь нь 3 хүртэлх, 8.1 мянга буюу 26.7 хувь нь 3-5, 2.5 мянга буюу 8.4 хувь нь 6, түүнээс дээш ам бүлтэй өрхийг тэргүүлж байна.

Улсын хэмжээнд 8, түүнээс дээш ам бүлтэй өрхийн тоо 2012 онд 13.2 мянга болж, өмнөх оныхоос 787 өрхөөр буюу 5.6 хувь, 16 хүртэлх насны 4, түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо

23.5 мянга болж, 640 өрхөөр буюу 2.7 хувиар буурчээ (Зураг III.18).

Ганцаар амьдардаг өндөр настай хүний тоо 24.5 мянга болж, өмнөх оныхоос 1318 хүн буюу 5.7 хувиар нэмэгдэв. Үүнээс 7.5 мянга нь 60, түүнээс дээш насны эрэгтэйчүүд; 17.0 мянга нь 55, түүнээс дээш насны эмэгтэйчүүд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 2012 онд 92.3 мянга болж, өмнөх оныхоос 5398 хүн буюу 6.2 хувиар өсч, үүнээс 46.2 хувь нь эмэгтэйчүүд, 80.5 хувь нь хөдөлмөрийн насны иргэд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 32.9 хувь нь төрөлхийн, 67.1 хувь нь олдмол үүнээс 70.6 хувь нь ердийн өвчнөөс, 11.4 хувь нь мэргэжлээс шалтгаалах өвчнөөс, 14.5 хувь нь ахуйн ослоор, 3.5 хувь нь үйлдвэрлэлийн ослоос болжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 9.6 мянга буюу 10.4 хувь нь харах эрхтний, 10.3 мянга буюу 11.2 хувь нь сонсгол хэл ярианы, 17.6 мянга буюу 19.1 хувь нь хөдөлгөөний согогтой, 10.0 мянга буюу 10.9 хувь нь оюун ухааны хомсдолтой, 10.0 мянга буюу 10.9 хувь нь сэтгэцийн эмгэгтэй, 9.7 мянга буюу 10.5 хувь нь хавсарсан согогтой, 25.0 мянга буюу 27.0 хувь нь бусад хэлбэрийн согогтой байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо 2012 онд 8.0 мянга болж, нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 8.7 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оныхоос 194 буюу 2.4 хувиар буурав. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 66.7 хувь нь төрөлхийн, 33.3 хувь нь олдмол байна.

Зураг-I.8

**Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо, ам бүлийн тоогоор, жилийн эцсийн байдлаар**




Зураг-I.9

**8, түүнээс дээш ам бүлтэй, 16 хүртэлх насны 4, түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо, жил бүрийн эцсийн байдлаар**




## I.4 Нийгмийн даатгал, халамж

### Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2012 онд 1106.9 тэрбум төг, зарлага 943.4 тэрбум төг болж, өмнөх оныхоос орлого 343.6 тэрбум төг буюу 45.0 хувь, зарлага 336.3 тэрбум төг буюу 55.4 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2012 онд өмнөх оныхоос 343.6 тэрбум төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 273.1 тэрбум төг буюу 51.3 хувь, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 14.1 тэрбум төг буюу 47.9 хувь, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 11.5 тэрбум төг буюу 42.6 хувь, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн орлого 16.4 тэрбум төг буюу 35.8 хувь, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 28.6 тэрбум төг буюу 22.2 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Нийгмийн даатгалын сангийн зарлага 2012 онд өмнөх оныхоос 336.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 279.3 тэрбум төг буюу 61.6 хувь, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 16.4 тэрбум төг буюу 51.0 хувь, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн зарлага 10.1 тэрбум төг буюу 46.5 хувь, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 3.1 тэрбум төг буюу 35.8 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 27.4 тэрбум төг буюу 30.0 хувиар өссөн нь нөлөөлөв.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2012 онд 709.6 тэрбум төг болсны 72.9 хувийг өндөр настны, 12.3 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 8.7 хувийг цэргийн, 6.1 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэвэр эзэлж байгаа нь өмнөх оноос цэргийн тэтгэвэр 2 дахин, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох тэтгэвэр 62.0 хувь, өндөр настны тэтгэвэр 57.8 хувь, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 53.1 хувиар өсчээ. ( Зураг I.10)

Нийгмийн даатгалд 2012 онд 741.4 мян.хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 504.3 мянга буюу 68.0 хувь нь аж ахуйн нэгж байгууллагынх, 237.1 мянга буюу 32.0 хувь нь төсөвт байгууллагынх байгаа бөгөөд өмнөх оныхоос нийт шимтгэл төлөгч, даатгуулагчдын тоо 87.9 мянга буюу 13.4 хувь, үүнээс аж ахуйн нэгж, байгууллагынх 75.3 мянга буюу 17.6 хувь, төсөвт байгууллагынх 12.6 мянга буюу 5.6 хувиар нэмэгджээ.

## Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2012 онд 182.3 мян.хүнд 111.4 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон бөгөөд өмнөх оныхоос нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо 7.8 мян.хүн буюу 4.5 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 43.8 тэрбум төг буюу 64.8 хувиар өсчээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдагчдын 49.3 хувь нь жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, 33.3 хувь нь халамжийн тэтгэвэр авагчид, 8.2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэд, 8.0 хувь нь ахмад настныг асарч буй иргэд, 1.2 хувь нь бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөж буй иргэд байна. (Зураг I.11).

Нийгмийн халамжийн сангаас 2012 онд олгосон нийт тэтгэвэр, тэтгэмжийн 64.6 тэрбум төг буюу 58.0 хувийг халамжийн тэтгэвэрт, 32.4 тэрбум төг буюу 29.0 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд, 6.7 тэрбум төг буюу 6.0 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэдэд, 6.6 тэрбум төг буюу 6.0 хувийг ахмад настныг асарч буй иргэдэд, 1.1 тэрбум төг буюу 1.0 хувийг бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсний тэтгэмжид зарцуулсан байна. (Зураг I.12).

Зураг-I.10

**Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн бүтэц, төрлөөр, 2012 оны жилийн эцсийн байдлаар**




Зураг-I.11

**Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдагчдын бүтэц, 2012 оны жилийн эцсийн байдлаар**




Зураг-I.12

**Нийгмийн халамжийн сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц, 2012 оны жилийн эцсийн байдлаар**



Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2012 онд 60.7 мян.хүн хамрагдсан нь өмнөх оныхоос 3.8 мян.хүн буюу 6.8 хувь, олгосон тэтгэврийн хэмжээ 29.3 тэрбум төг буюу 82.8 хувиар нэмэгджээ.

Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөд 353.6 мян.хүн хамрагдсаны 31.1 хувь нь ахмад настан, 1.4 хувь нь алдар цолтой ахмад настан, 4.3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 58.7 хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, 4.5 хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд байна.

Хүний хөгжил сангаас 2012 онд давхардсан тоогоор 18 хүртэлх насны 976.2 мянган хүүхдэд 53.3 тэрбум төгрөгийн хүүхдийн мөнгө олгожээ.

Хүний хөгжил сангаас 2012 онд 693.7 тэрбум төгрөгийн хишиг хувийг давхардсан тоогоор 2.8 сая иргэнд олгосны 375.5 тэрбум төгрөгийг 10.0, 21.0, 70.0 мян.төгрөгийн хишиг хувьд, 318.2 тэрбум төгрөгийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох 1.0 сая төгрөгийн хишиг хувьд зарцуулжээ.

## I.5 Боловсрол

Бүх шатны сургуульд суралцагчдын тоо 2012/2013 оны хичээлийн жилийн эхэнд 897.9 мян.хүн болж, өмнөх оныхоос 7.3 мян.хүнээр буюу 0.8 хувиар нэмэгдэв.(Зураг I.13)

Бүх шатны сургуулийг 2011/2012 оны хичээлийн жилд 167.8 мян.суралцагчид төгссөнөөс ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийг 107.0 мян.сурагч (9-р ангийг 66.8 мянга, 11-р ангийг 38.6 мянга), мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-ийг 23.1 мян.суралцагчид, их, дээд сургууль, коллежийг 37.7 мян.оюутан төгсчээ. (Зураг I.14)

Улсын хэмжээнд 2012/2013 оны хичээлийн жилд 945 цэцэрлэгт 181.0 мян. хүүхэд хүмүүжиж байгаа нь өмнөх оныхоос цэцэрлэгийн тоо 66-аар буюу 7.5 хувиар, хүүхдийн тоо 16.7 мянга буюу 10.2 хувиар өссөн байна. Цэцэрлэгийн бүлгийн тоо 5630 болж, өмнөх оныхоос 377-оор буюу 7.2 хувиар нэмэгдлээ.

Ерөнхий боловсролын 755 сургуульд 2012/2013 оны хичээлийн жилд 496.1 мян. сурагчид суралцаж байгаа нь өмнөх оныхоос сургуулийн тоо 3-аар буюу 0.4 хувиар нэмэгдэж, суралцагчдын тоо 9.3 мян.буюу 1.8 хувиар буурав. Нийт суралцагчдын 245.4 мянга нь 1-5 дугаар ангид, 155.3 мянга нь 6-9 дүгээр ангид, 95.4 мянга нь 10-12 дугаар ангид суралцаж байна.

Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчдын тоо Улаанбаатар хотод өмнөх оныхоос 0.1 хувиар, Говьсүмбэр аймагт 3.4 хувиар өсч, Дорноговь аймагт өмнөх оны түвшинд байгаа бол бусад аймагт 1.0-6.1 хувиар буурлаа. 2012/2013 оны хичээлийн

Зураг-I.13

**Бүх шатны сургуульд суралцагчид*, хичээлийн жилийн эхэнд, мян.хүн**




Зураг-I.14

**Бүх шатны сургуулийг төгсөгчид, мян.хүн**



жилд ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид 47.6 мян.хүүхэд элсэн орсон нь өмнөх оныхоос 0.9 мян.хүүхдээр буюу 2.0 хувиар өсчээ. Дотуур байранд нийт 36.1 мян. сурагч амьдарч байгаагийн 18.9 мян.буюу 52.4 хувь нь эмэгтэй, 30.5 мянга буюу 84.5 хувь нь малчдын хүүхэд байна.

2012/2013 оны хичээлийн жилд мэргэжлийн сургалт үйлдвэрлэл (МСҮ)-ийн 75 төв үйл ажиллагаа явуулж байгаагийн 49 нь төрийн өмчийн, 26 нь хувийн өмчийн сургууль байна. Нийт МСҮТ-ийн 40 нь бие даасан, 13 нь коллежийн харьяа, 7 нь дээд сургуулийн харьяа, 15 нь их сургуулийн харьяа байна. Энэ хичээлийн жилд МСҮ-ийн 5 төв шинээр үйл ажиллагаагаа эхэлсэн байна. 2012/2013 оны хичээлийн жилд МСҮТ-д 45.2 мян. суралцагчид суралцаж байгаа нь өмнөх оныхоос 2.9 мянга буюу 6.0 хувиар буурсан байна. 2012/2013 оны хичээлийн жилд суурь боловсрол эзэмшигчдийн 16.1 хувь нь МСҮТ-д элсэн суралцаж байна. 2012/2013 оны хичээлийн жилд нийт 99 их, дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулж байгаагийн 15 нь төрийн өмчийн, 79 нь төрийн өмчийн бус, 5 нь гадаадын сургуулийн салбар байна. Улаанбаатар хотод 90, хөдөө орон нутагт 9 их, дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулж байна. Их, дээд сургууль, коллежийн тоо өмнөх оныхоос 2-оор буурчээ. Их, дээд сургууль, коллежид 175.6 мян.оюутан суралцаж байгаа нь 2011/2012 оны хичээлийн жилийнхээс 2.8 мян.буюу 1.6 хувиар нэмэгдсэн байна. Их, дээд сургууль, коллежид суралцагчдын 155.8 мянга буюу 88.7 хувь нь бакалаврын түвшний сургалтад хамрагдаж байна.

Их, дээд сургууль, коллежид суралцагчдын 61.2 мянга буюу 34.8 хувь нь нийгмийн ухааны, 33.7 мянга буюу 19.2 хувь нь техник, технологийн, 22.1 мянга буюу 12.6 хувь нь боловсролын, 17.6 мянга буюу 10.0 хувь нь анагаах ухааны, 13.4 мянга буюу 7.6 хувь нь хүмүүнлэгийн, 11.8 мянга буюу 6.7 хувь нь байгалийн шинжлэх ухааны, 9.2 мян.буюу 5.3 хувь нь үйлчилгээний салбарын, 6.1 мянга буюу 3.5 хувь нь хөдөө аж ахуйн, 0.5 мянга буюу 0.3 хувь нь бусад салбарын мэргэжлээр суралцаж байна.

Зураг-I.15

**Нэг багшид ногдох сурагчдын тоо**




2011/2012 оны хичээлийн жилд нийт 37.7 мян.оюутан төгссөн нь өмнөх оныхоос 5.3 хувиар нэмэгдэв. Нийт төгсөгчдийн 64.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Төгсөгчдийн 40.0 хувь нь нийгмийн шинжлэх ухааны, 5.4 хувь нь байгалийн шинжлэх ухааны, 17.5 хувь нь багш, сурган хүмүүжүүлэх, 11.4 хувь нь инженер, техник, технологийн, 8.8 хувь нь хүмүүнлэгийн ухаан, урлагийн, 7.9 хувь нь эрүүл мэндийн, 2.2 хувь нь хөдөө аж ахуйн, 5.3 хувь нь үйлчилгээний, 1.5 хувь нь бусад салбарын мэргэжлээр төгссөн нь өмнөх оныхоос байгалийн ухаан, эрүүл мэндийн салбарын мэргэжлээр төгсөгчдийн тоо 4.4-5.1 хувиар буурч, харин техник, технологи, нийгэм, хүмүүнлэг, үйлчилгээ, хөдөө аж ахуй, багш сурган хүмүүжүүлэх мэргэжлээр төгсөгчдийн тоо 3.0-14.7 хувиар өссөн байна.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн нэг багшид ногдох сурагчдын тоо 2012/2013 оны хичээлийн жилд 20.2 болж, өмнөх оныхоос 2 хүнээр буюу 12.2 хувиар буурчээ. Цэцэрлэгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо, их, дээд сургууль, коллежийн нэг багшид ногдох сурагчдын тоо 2012/2013 оны хичээлийн жилд өмнөх оныхтой ижил түвшинд байна. (Зураг I.15)

## I.6 Эрүүл мэнд

Улсын хэмжээнд 2012 онд 74474 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 74778 болж, өмнөх оныхоос амаржсан эхийн тоо 4146 эхээр буюу 5.9 хувиар, хүүхдийн тоо 4202 хүүхдээр буюу 6.0 хувиар тус тус өссөн байна (Зураг I.6). Харин 2012 оны 12 дугаар сард 6160 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оны мөн үеийнхээс 494 хүүхэд буюу 8.7 хувиар нэмэгдлээ.

Улсын хэмжээгээр 2012 онд нялхсын эндэгдэл 1143 болж, өмнөх оныхоос 9 хүүхэд буюу 0.8 хувь, 1-5 хүртэлх насандаа 253 хүүхэд эндэж, өмнөх оныхоос 5 хүүхдээр буурсан байна (Зураг I.17). Жирэмслэлт болон төрөлтийн улмаас 2012 онд 37 эх, 12 дугаар сард 5 эх эндсэн байна.

Нялхсын эндэгдэл 2012 оны 12 дугаар сард 114 болж, өмнөх оны мөн үеийнхээс 17 хүүхдээр нэмэгдэж, 1-5 хүртэлх насандаа 23 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс 5 хүүхдээр буурав.

1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 2012 онд 15 болж, өмнөх оныхоос 1 хүүхдээр буурсан бөгөөд энэ үзүүлэлт Хөвсгөл (26), Баян-Өлгий (23), Завхан (23), Өвөрхангай (23), Сүхбаатар (22) аймагт улсын дунджаас 7-11 хүүхдээр, Говь-Алтай (20), Архангай (20), Төв (20), Булган (19), Ховд (18), Өмнөговь (17), Дорноговь (16), Хэнтий (16) аймагт 1-5 хүүхдээр илүү байна.

Тав хүртэлх насны* хүүхдийн эндэгдэл 2012 оны 12 дугаар сард 137 болж, өмнөх оны мөн үеийнхээс 12 хүүхдээр нэмэгдсэн байна. Харин 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2012 онд 19 болж, өмнөх оныхоос 1 хүүхдээр буурчээ.

Халдварт өвчнөөр 2012 онд 43305 хүн өвчилж, өмнөх оныхоос 466 хүн буюу 1.1 хувиар нэмэгдсэн нь вирүст хепатитаар өвчлөгчдийн тоо 7816 хүн буюу 53.3 хувь, салхин цэцгээр 291 хүн буюу 9.4 хувь, цусан суулгаар 69 хүн буюу 3.3 хувь, сүрьеэгээр өвчлөгчдийн тоо 41 хүн буюу 1.0 хувиар буурсан хэдий ч гахайн хавдраар өвчлөгчдийн тоо 8044 хүн буюу 8.9 дахин, тэмбүүгээр 686 хүн буюу 16.1 хувь, трихомониазаар 158 хүн буюу 4.0 хувь, гонококкт халдвараар өвчлөгчдийн тоо 192 хүн буюу 3.7 хувиар өссөнөөс голлон шалтгаалав.

Зураг-I.16

**Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эцсийн байдлаар**




Зураг-I.17

**Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн эцсийн байдлаар**




Халдварт өвчнөөр 2012 оны 12 дугаар сард 4008 хүн өвчилж, өмнөх оны мөн үеийнхээс 403 хүн буюу 9.1 хувиар буурахад вирүст хепатитаар өвчлөгчдийн тоо 1588 хүн буюу 77.1 хувиар буурсан нь нөлөөлөв. Харин энэ хугацаанд гахайн хавдраар өвчлөгчдийн тоо 636 хүн буюу 6.1 дахин, тэмбүүгээр 220 хүн буюу 68.5 хувь, трихомониазаар 181 хүн буюу 66.7 хувь, гонококкт халдвараар 221 хүн буюу 53.9 хувь, салхин цэцгээр 67 хүн буюу 23.8 хувь, сүрьеэгээр 30 хүн буюу 13.5 хувь, цусан суулгаар өвчлөгчдийн тоо 10 хүн буюу 12.2 хувиар нэмэгдэв.

*Тайлбар: *Тав хүртэлх насны хүүхдэд 0-4 нас 365 хүртэл хоногтой хүүхдийг хамруулав.*

10 000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 2012 онд улсын дунджаар 157 болж, өмнөх оныхоос 6 хүнээр нэмэгдэв (Зураг I.18).

Улаанбаатар хотод 2012 оны 12 дугаар сард ХДХВ/ДОХ-ын 9 тохиолдол илэрсэн ба улсын хэмжээнд бүртгэгдсэн ХДХВ/ДОХ-ын нийт тохиолдол 127 боллоо.

Улсын хэмжээнд 2012 онд 16923 хүн нас барсан нь өмнөх оныхоос 204 хүн буюу 1.2 хувиар буурав (Зураг I.19). Эмнэлэгт нас барсан хүний тоо 2012 онд 4170 болж, өмнөх оныхоос 6 хүн буюу 0.1 хувиар буурчээ. Энэ нь нийт нас баралтын 24.6 хувийг эзэлж байна. Нас барсан хүний тоо 2012 оны 12 дугаар сард 1400 болж, өмнөх оны мөн үеийнхээс 3 хүн буюу 0.2 хувиар буурав.

Эмнэлэгт 2012 онд 718.6 мян.хүн хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оныхоос 24301 хүн буюу 3.5 хувиар нэмэгдэв. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 2012 оны 12 дугаар сард 65.8 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 516 хүн буюу 0.8 хувиар нэмэгдсэн байна.

Хувийн эмнэлгүүд 2012 онд 1499.4 мян.хүнд үйлчилж, 49.1 тэрбум төгрөгийн төлбөртэй үйлчилгээ үзүүлжээ. Хувийн эмнэлгээр үйлчлүүлсэн хүний тоо өмнөх оныхоос 7.6 хувиар нэмэгдэж, төлбөрт үйлчилгээний хэмжээ 25.3 хувиар өслөө.

## I.7 Гэмт хэрэг

Улсын хэмжээнд 2012 онд 22089 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 2892 хэргээр буюу 15.1 хувиар өсчээ (Зураг I.20). Өмнөх оныхоос нийт гэмт хэргийн тоо нэмэгдэхэд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (1791), хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг (693), байгаль хамгаалах журмын эсрэг (140), тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг (129) зэрэг гэмт хэрэг өссөн нь голлон нөлөөлөв.

2012 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 58.4 хувь нь нийслэлд, 40.9 хувь нь аймгуудад, 0.4 хувь нь төмөр замын цагдаагийн хэлтэст, 0.1 хувь нь иргэний агаарын тээврийн салбарт, 0.2 хувь нь бусад газарт бүртгэгджээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 45.5 хувийг хүндэвтэр, 43.6 хувийг хөнгөн, 8.7 хувийг хүнд, 2.2 хувийг онц хүнд гэмт хэрэг эзэлж, өмнөх оныхоос хөнгөн хэргийнх 2.0 пунктээр нэмэгдэж, хүндэвтэр хэргийнх 0.8 пункт, хүнд

Зураг-I.18

**10 000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн эцсийн байдлаар**




Зураг-I.19

**Нас барсан хүний тоо, жил бүрийн эцсийн байдлаар**




Зураг-I.20

**Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эцсийн байдлаар**



хэргийнх 0.8 пункт, онц хүнд хэргийнх 0.4 пунктээр буурсан байна (Зураг I.21).

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оныхоос Дорнод аймагт 40.0 хувь, Баян-Өлгий аймагт 35.4 хувь, Говьсүмбэр аймагт 34.5 хувь, Булган аймагт 20.5 хувь, Өвөрхангай аймагт 15.2 хувь, Төв аймагт 15.1 хувь, Говь-Алтай аймагт 14.2 хувь, Сэлэнгэ аймагт 13.9 хувь, Сүхбаатар аймагт 13.1 хувь, Дархан-Уул аймагт 11.1 хувь, Өмнөговь аймагт 10.8 хувь, Завхан аймагт 10.6 хувь, Архангай аймагт 8.6 хувь, Орхон аймагт 13.3 хувь, Дорноговь аймагт 6.6 хувь, Хөвсгөл аймагт 3.9 хувь, Улаанбаатар хотод 19.8 хувиар нэмэгдэж, харин Увс аймагт 15.7 хувь, Хэнтий аймагт 13.2 хувь, Ховд аймагт 3.6 хувь, Баянхонгор аймагт 3.2 хувь, Дундговь аймагт 2.4 хувиар буурчээ.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 534 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 114 хэрэг буюу 27.1 хувиар нэмэгдсэн байна. Малын хулгайн 1376 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 6.2 хувийг эзэлж, өмнөх оныхоос 207 хэрэг буюу 17.7 хувиар өсчээ.

Сэжигтэн нь тодорхойгүй байсан 8140 хэргийн 4585 буюу 56.3 хувийнх нь холбогдогч нь тогтоогдож, яллагдагчаар татагдсанаар гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд өмнөх оныхоос 5.2 пунктээр, нийслэлийн хэмжээнд 7.1 пунктээр буурсан байна. (Зураг I.22).

Эмэгтэй хүн оролцсон хэрэг 2012 онд өмнөх оныхоос 85.2 хувь, хүүхэд оролцсон гэмт хэрэг 82.4 хувь, бүлэглэн үйлдэгдсэн хэрэг 17.5 хувь, согтуугаар үйлдэгдсэн хэрэг 17.4 хувь, галт зэвсгээр үйлдэгдсэн хэрэг 5.1 хувиар нэмэгдэв.

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэргийн тоо улсын дунджаар 2012 онд 117 болж, өмнөх оныхоос 13 хэрэг буюу 12.5 хувиар нэмэгдэв.

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч 2012 онд 19734 байгаагийн 1248 буюу 6.3 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 2667 буюу 13.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Гэмт хэрэгт холбогдогчдын 4.6 хувь нь өмнө нь ял шийтгэгдсэн хүмүүс байгаа бөгөөд тэдгээрийн эзлэх хувь өмнөх оныхоос 0.9 пунктээр буурчээ.

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдад хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн

Зураг-I.21

**Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэргийн ангиллаар, жил бүрийн эцсийн байдлаар, хувиар**




Зураг-I.22

**Гэмт хэргийн илрүүлэлт, жил бүрийн эцсийн байдлаар, хувиар**




Зураг-I.23

**Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын нийгмийн байдал, жил бүрийн эцсийн байдлаар, хувиар**



эзлэх хувь 2012 онд 12.1 болж, өмнөх оныхоос 3.3 пункт, малчдынх 9.5 хувь болж 0.7 пункт, оюутан, сурагчдынх 7.2 хувь болж 0.4 пункт, төрийн бус байгууллагын ажиллагчдынх 1.9 хувь болж 0.1 пунктээр нэмэгдэж, харин ажилгүй иргэдийнх 52.7 хувь болж 3.4 пункт, аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдынх 11.1 хувь болж 0.6 пункт, төрийн албан хаагчдынх 4.3 хувь болж 0.9 пунктээр буурсан байна.

2012 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 29.2 хувь нь гэр, орон сууцанд, 17.0 хувь нь гудамж, талбайд, 13.3 хувь нь олон нийтийн газарт, 7.6 хувь нь аж ахуйн нэгжид, 8.3 хувь нь авто замд, 2.2 хувь нь төрийн байгууллагад, 1.3 хувь нь төрийн бус байгууллагад, 1.3 хувь нь нийтийн тээврийн хэрэгсэлд, 19.8 хувь нь бусад газарт үйлдэгджээ.

Гэмт хэргийн улмаас 8436 хүн гэмтэж, 901 хүн нас барсан нь өмнөх оныхоос гэмтсэн хүний тоо 336 буюу 4.1 хувиар өсч, нас барсан хүний тоо 21 буюу 2.3 хувиар буурсан байна (Зураг I.24).

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2012 онд 53.3 тэрбум төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 25.1 тэрбум төг болж, өмнөх оныхоос учирсан хохирлын хэмжээ 17359.1 сая төг буюу 48.3 хувиар, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 6645.2 сая төг буюу 35.9 хувиар өссөн байна (Зураг I.25).

Нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ нэмэгдэхэд хувийн өмчийн байгууллагад учирсан хохирлын нөхөн төлүүлэлт 6739.1 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлөв. Гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирлын 80.4 хувь буюу 42.8 тэрбум төг нь хувийн өмчид ногдож байна.

Гэмт хэргийн улмаас хохирсон иргэд 2012 онд 21294 байгаагийн 1270 буюу 6.0 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 7977 буюу 37.5 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг-I.24

**Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн эцсийн байдлаар**




Зураг-II.25

**Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн эцсийн байдлаар, тэрбум төгрөгөөр**




Гэмт хэргийн улмаас нийт 167 байгууллагад хохирол учирсны 88 нь төрийн, 24 нь төрийн бус, 55 нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага байна.

Улсын хэмжээнд 2012 онд 118.0 мян.хүн эрүүлжүүлэгдэж, 13.9 мян.хүн баривчлагдсан нь өмнөх оныхоос эрүүлжүүлэгдсэн хүний тоо 2681 буюу 2.3 хувь, баривчлагдсан хүний тоо 1508 буюу 12.2 хувиар өссөн байна.

## II.Макро эдийн засгийн үзүүлэлт

### II.1 Дотоодын нийт бүтээгдэхүүн

### ДНБ, үйлдвэрлэлийн аргаар

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ий хэмжээ 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 13944.2 тэрбум төгрөг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 5492.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос оны үнээр 2856.5 тэрбум төгрөг буюу 25.8 хувь, зэрэгцүүлэх үнээр 600.9 тэрбум төгрөг буюу 12.3 хувиар өслөө (Зураг II.1).

ДНБ-ий 2012 оны бодит өсөлтөд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 21.3 хувь, уул уурхай, олборлох салбарынх 8.9 хувь,

Зураг-II.1

**ДНБ-ий жилийн өсөлт, хувиар**



тээврийн салбарынх 12.8 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний салбарынх 10.3 хувь тус тус өссөн нь голлон нөлөөллөө.

ДНБ-ий бодит өсөлтийг улирлаар авч үзвэл, 2012 оны эхний улиралд 14.6 хувь, эхний хагас жилд 14.5 хувь, эхний 3 улиралд 12.9 хувь, харин жилийн эцсийн гүйцэтгэлээр 12.3 хувиар өссөн байна (Зураг 6.2).

**ДНБ, эцсийн ашиглалтын аргаар**

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ий хэмжээ 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 14621.1 тэрбум төгрөг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 5509.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос оны үнээр 3452.9 тэрбум төгрөг буюу 30.9 хувь, зэрэгцүүлэх үнээр 598.6 тэрбум төгрөг буюу 12.2 хувиар өслөө.

2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ-д эцсийн хэрэглээ 64.2 хувь, хөрөнгийн нийт хуримтлал 60.6 хувь, цэвэр экспорт -24.7 хувийг эзэлж, өмнөх оныхоос эцсийн хэрэглээ 1.9 пунктээр өсч, цэвэр экспорт 0.4 пункт, хөрөнгийн нийт хуримтлал 1.5 пунктээр буурсан байна (Зураг 6.2).

Бүтцийн энэ өөрчлөлтөд 2012 онд эцсийн хэрэглээ өссөн нь голлон нөлөөллөө.

Зураг-II.2

**ДНБ-ий өсөлт, бууралт, хувиар**

(үйлдвэрлэлийн аргаар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр)




Зураг-II.3

**ДНБ-ий эцсийн ашиглалтын бүтэц, оны үнээр**




## II.2 Үнэ

### Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮУИ) 2012 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 0.8 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 14.0 хувиар өслөө (Хүснэгт II.1). Инфляцийн жилийн дундаж түвшин 14.3 хувь байв.

Хэрэглээний үнийн улсын индекс 2012 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеийнхээс 14.0 хувь өссөний дотор хүнс, ундаа, усны бүлгийн барааны үнэ дүнгээрээ 17.5 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийнх 54.4 хувь, хувцас, бөс бараа, гутлынх 16.1 хувь, боловсролын үйлчилгээний бүлгийнх 15.2 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур

Хүснэгт-II.1

**Хэрэглээний үнийн улсын индекс, бүлгийн дүнгээр**

| Бараа, үйлчилгээний бүлэг | Жин | 2012 XII / 2011 XII | 2012 XII / 2012 XI |
|---|---|---|---|
| **Ерөнхий индекс** | **100.0** | **114.0** | **100.8** |
| Хүнсний бараа, ундаа, ус | 29.3 | 117.5 | 101.7 |
| Согтууруулах ундаа, тамхи | 3.2 | 154.4 | 100.7 |
| Хувцас, бөс бараа, гутал | 16.1 | 116.1 | 100.9 |
| Орон сууц, ус, цахилгаан, түлш | 12.3 | 111.0 | 99.7 |
| Гэр ахуйн тавилга, бараа | 4.7 | 110.2 | 100.6 |
| Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ | 3.6 | 109.0 | 100.1 |
| Тээвэр | 12.2 | 106.5 | 101.1 |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 4.4 | 98.5 | 100.0 |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 2.8 | 103.5 | 100.0 |
| Боловсролын үйлчилгээ | 4.7 | 115.2 | 100.0 |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 2.6 | 123.0 | 100.2 |
| Бусад бараа, үйлчилгээ | 4.1 | 107.4 | 100.2 |

байрны үйлчилгээнийх 23.0 хувиар нэмэгдсэн нь өндөр өсөлт бөгөөд холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ 1.5 хувиар буурч, эдгээрээс бусад бүлгийн үнэ 3.5-11.0 хувиар өсчээ.

Ерөнхий индекс 2012 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 0.8 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.7 хувь, тээврийн бүлгийнх 1.1 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.7 хувь, хувцас, бөс бараа, гутлынх 0.9 хувь, гэр ахуйн тавилга, барааных 0.6 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээнийх 0.1 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээнийх 0.2 хувь, бусад бараа, үйлчилгээнийх 0.2 хувиар өсч, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ болон боловсролын үйлчилгээний бүлгийн дүн тогтвортой харин орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 0.3 хувиар буурчээ.

Хэрэглээний үнийн улсын индекс 2011 оны 12 дугаар сард оны эхнээс 10.2 хувиар өссөн бол 2012 оны 12 дугаар сард 14.0 хувь болж, өсөлт 3.8 пунктээр нэмэгджээ (Зураг II.5).

Хэрэглээний үнийн сарын индекс улсын дүнгээр 2012 оны 1,2, 3 дугаар сард өмнөх сарынхаас 2.2-2.7 хувиар, бусад саруудад 0.2-1.0 хувиар өссөн байна. Хэрэглээний үнэ 2012 оны 1 дүгээр сард 2.7 хувиар өссөн нь хамгийн өндөр өсөлт байлаа. 2012 оны сарын дундаж өсөлт 1.1 хувьтай байв. (Зураг II.6).

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2012 оны эцэст өмнөх оныхоос Улаанбаатар хот болон бүх аймагт 7.7-23.7 хувиар өсчээ. Үнийн өсөлт Улаанбаатар хот, Баян-Өлгий, Дорнод, Ховд, Архангай, Баянхонгор, Орхон, Завхан, Говьсүмбэр аймагт улсын дунджаас 0.2-9.7 пунктээр илүү байлаа (Зураг II.7).

Өрхийн нийт хэрэглээнд өндөр хувийн жин эзэлж буй мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ дүнгээрээ 2012 оны эцэст өмнөх оныхоос бүх аймагт 20.1-51.9 хувиар өссөний дотор Говьсүмбэр (51.9%) аймагт хамгийн өндөр өсөлттэй байв.

Талх, гурил, будааны дэд бүлгийн үнэ дүнгээрээ Дундговь (5.0%), Өвөрхангай (4.2%), Дорнод (0.8%), Булган (0.3%) аймагт буурч, бусад 17 аймагт 0.3-27.4 хувиар өссөн байна.

Зураг-II.4

**Хэрэглээний үнийн улсын индекс (өмнөх оны 12 сар =100)**




Зураг-II.5

**Хэрэглээний үнийн улсын индекс, 2012 он, сар бүрээр, (өмнөх сар=100)**




Зураг-II.6

**Хэрэглээний үнийн индекс, нийслэл, аймгаар, 2012 оны жилийн эцэст (өмнөх оны 12 сар =100%)**



Баян-Өлгий (27.4%) аймагт хамгийн өндөр өсөлттэй байлаа.

Сүү, сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ дүнгээрээ Говьсүмбэр (10.3%), Говь-Алтай (9.3%), Дундговь (6.9%), Орхон (1.0%) аймагт буурч, бусад 17 аймагт 1.0-17.9 хувиар өссөн байна. Ховд (17.9%), Өмнөговь (17.1%) аймагт хамгийн их өсөлттэй байв.

Төмс, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ дүнгээрээ Баян-Өлгий (24.7%), Говьсүмбэр (18.5%), Сэлэнгэ (9.3%), Архангай (5.6%), Хэнтий (4.0%), Увс (4.0%) аймагт буурч, бусад 15 аймагт 0.5-26.1 хувиар өсчээ. Орхон (26.1%) аймагт хамгийн их өсөлттэй байлаа.

Хэрэглээний үнийн индекс 2012 оны 12 дугаар сард өмнөх сартай харьцуулахад Сэлэнгэ (0.5%), Говьсүмбэр (0.2%) аймагт буурч, Улаанбаатар хот болон бусад 19 аймагт 0.3-3.2 хувиар өссөн байна.

Булган аймагт хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2012 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 3.2 хувиар өссөн нь хамгийн өндөр үзүүлэлт юм. Тус аймагт үнэ өсөхөд хүнсний бүлгийн барааны үнэ дүнгээрээ 2.7 хувь, хувцас, бөс бараа, гутлынх 10.4 хувь, үүний дотор гутлын дэд бүлгийн үнэ 15.1 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Сэлэнгэ аймагт хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс 0.5 хувиар буурсан дүнтэй байна. Үнийн бууралтад хувцас, бөс бараа, гутлын бүлгийн барааны үнэ дүнгээрээ 3.6 хувиар хямдарсан нь нөлөөлжээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2012 оны 12 дугаар сард Улаанбаатар хотод өмнөх сарынхаас 0.7 хувь, өмнөх оны эцсийнхээс 14.2 хувиар өслөө.

Хэрэглээний үнийн ерөнхий индекс Улаанбаатар хотод 2012 оны 12 дугаар сард өмнөх оны эцсийнхээс 14.2 хувь өссөний дотор согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 54.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрных 21.8 хувь, хүнсний бараа, ундаа, усных 19.9 хувь, боловсролын үйлчилгээнийх 16.1 хувь, хувцас, гутал, бөс барааных 13.0 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээнийх 11.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшнийх 8.7 хувь, тээврийнх 7.5 хувь, бусад бараа, үйлчилгээнийх 6.0 хувь, гэр ахуйн бараа, тавилгынх 4.5 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээнийх 3.8 хувиар өсч, харин холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээнийх 1.2 хувиар буурчээ. (Зураг II.7).

Улаанбаатар хотод 2012 оны эцэст өмнөх оныхоос хэрэглээний сагсны 329 нэрийн бараа, үйлчилгээний 75.1 хувийнх нь үнэ өсч, 9.1 хувийнх нь үнэ буурч, 15.8 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Судалгаанд сонгогдсон хүнсний 93 нэрийн барааны 90.3 хувь буюу 84 нэрийн барааны үнэ нэмэгджээ.

Зураг-II.7

**Улаанбаатар хотын хэрэглээний үнийн өмнөх оны эцсийнхээс өөрчлөгдсөн хувь, бүлгийн дүнгээр**



(18.5%), Сэлэнгэ (9.3%), Архангай (5.6%), Хэнтий (4.0%), Увс (4.0%) аймагт буурч, бусад 15 аймагт 0.5-26.1 хувиар өсчээ. Орхон (26.1%) аймагт хамгийн их өсөлттэй байлаа.

Хэрэглээний үнийн индекс 2012 оны 12 дугаар сард өмнөх сартай харьцуулахад Сэлэнгэ (0.5%), Говьсүмбэр (0.2%) аймагт буурч, Улаанбаатар хот болон бусад 19 аймагт 0.3-3.2 хувиар өссөн байна.

Булган аймагт хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2012 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 3.2 хувиар өссөн нь хамгийн өндөр үзүүлэлт юм. Тус аймагт үнэ өсөхөд хүнсний бүлгийн барааны үнэ дүнгээрээ 2.7 хувь, хувцас, бөс бараа, гутлынх 10.4 хувь, үүний дотор гутлын дэд бүлгийн үнэ 15.1 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Сэлэнгэ аймагт хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс 0.5 хувиар буурсан дүнтэй байна. Үнийн бууралтад хувцас, бөс бараа, гутлын бүлгийн барааны үнэ дүнгээрээ 3.6 хувиар хямдарсан нь нөлөөлжээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2012 оны 12 дугаар сард Улаанбаатар хотод өмнөх сарынхаас 0.7 хувь, өмнөх оны эцсийнхээс 14.2 хувиар өслөө.

Хэрэглээний үнийн ерөнхий индекс 2012 оны 12 дугаар сард Улаанбаатар хотод өмнөх сарынхаас 0.7 хувиар нэмэгдэхэд хүнсний бараа, ундаа, ус болон тээврийн бүлгийн үнэ тус бүр 1.6 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Түүнчлэн согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.8 хувь, хувцас, бөс бараа, гутлынх 0.2 хувь, гэр ахуйн тавилга, барааных 0.6 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээнийх 0.1 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээнийх 0.1 хувь, бусад бараа, үйлчилгээнийх 0.3 хувиар өсч, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ болон боловсролын үйлчилгээний бүлгийн дүн тогтвортой, харин орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 0.7 хувиар буурчээ (Зураг II.8).

Зураг-II.8



## Улаанбаатар хотын хэрэглээний үнийн жилийн индекст нөлөөлсөн бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт

| Бараа, үйлчилгээний бүлэг | Үнийн өөрчлөлт, % | Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт |
|---|---|---|
| Хүнсний бараа, ундаа, ус | 19.9 | Энэ бүлгийн үнийн өсөлтөд мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 43.7 хувь, жимс, жимсгэнийх 21.0 хувь, төмс, хүнсний ногооных 8.7 хувь, сахар, чихрийнх 7.8 хувь, хүнсний бусад бүтээгдэхүүний үнэ 17.5 хувь, ундаа, усных 8.8 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. |
| Согтууруулах ундаа, тамхи | 54.6 | Согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнийн өсөлтөд архины үнэ 48.9-58.9 хувь, дарсных 7.9 хувь, шар айрагных 12.0-13.6 хувь, дотоодын болон импортын тамхиных 58.0 хувиас 2.1 дахин нэмэгдсэн нь нөлөөлөв. |
| Хувцас, бөс бараа, гутал | 13.0 | Энэ бүлгийн үнийн өсөлтөд хөвөн бөс барааны үнэ 14.1 хувь, эрэгтэй бэлэн хувцасны дэд бүлгийн үнэ 13.5 хувь, эмэгтэй хувцасных 19.5 хувь, хүүхдийнх 16.1 хувь, бүх төрлийн гутлынх 4.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. |
| Орон сууц, ус, цахилгаан, түлш | 8.7 | Энэ бүлгийн үнийн өсөлт нь орон сууцны бодит түрээсийн үнэ 37.5 хувь, орон сууцны засварын материалын үнэ 7.7 хувь, орон сууцны хог хаягдлын үнэ 8.5 хувь, СӨХ-нд төлөх засвар үйлчилгээний хөлс 44.3 хувь, 1 шуудай нүүрсний үнэ 4.7 хувь, түлшний модны үнэ 6.7 хувиар нэмэгдсэнтэй холбоотой байна. |
| Гэр ахуйн тавилга, бараа | 4.5 | Гэр ахуйн тавилга, барааны бүлгийн үнийн өсөлтөд гэрийн тавилга хэрэгслийн дэд бүлгийн үнэ 6.4 хувь, оёмол, нэхмэл эдлэлийнх 15.5 хувь, жижиг цахилгаан хэрэгслийнх 9.8 хувь, шилэн эдлэл, сав суулганых 20.2 хувь, гэр ахуйн багаж хэрэгслийнх 10.0 хувь, цэвэрлэгээний бодисын үнэ 7.5 хувиар өссөн нь нөлөөлжээ. |
| Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ | 11.7 | Энэ бүлгийн үнийн өсөлт нь эм, тарианы үнэ 3.6 хувь, амбулаторийн үзлэгийн хөлс 63.2 хувь, шүдэнд ломбо тавиулах хөлс 33.3 хувь, эмнэлгийн ор хоногийн хөлс 13.3 хувиар нэмэгдсэнтэй холбоотой. |
| Тээвэр | 7.5 | Тээврийн бүлгийн үнийн өсөлтөд судалгаанд сонгогдсон суудлын тэрэгний үнэ 9.8 хувь, унадаг дугуйны үнэ 33.3 хувь, автобензин, дизелийн түлшний үнэ 1.9-16.8 хувь, тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний үнэ 25.2 хувь, хот доторх таксины хөлс 8.3 хувиар өссөн нь нөлөөллөө. |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | -1.2 | Энэ бүлгийн үнийн бууралтад судалгаанд сонгогдсон гар утасны үнэ 26.8 хувь, олон улсын ярианы картын үнэ 8.3 хувь, интернэт кафед интернэт ашиглах хөлс 1.5 хувь, өрхийн интернетийн сарын төлбөр 2.8 хувиар буурсан нь нөлөөлөв. |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 3.8 | Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнэ өсөхөд тоглоом наадмын үнэ 14.6-66.7 хувь, спортын хэрэгслийнх 51.0-55.2 хувь, кабелийн телевизийн сарын хураамж 27.5 хувь, үзвэрийн тасалбарын үнэ 12.5-27.7 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ. |
| Боловсролын үйлчилгээ | 16.1 | Энэ бүлгийн үнэ дүнгээрээ 16.1 хувиар өссөн нь улсын их, дээд сургуулийн жилийн сургалтын төлбөр 9.8 хувь, хувийн дээд сургуулийнх 34.2 хувь, хувийн бага сургуулийнх 16.0 хувиар нэмэгдсэнтэй холбоотой байна. |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 21.8 | Энэ бүлгийн үнийн өсөлтөд нийтийн хоолны үйлчилгээний дэд бүлгийн үнэ 21.9 хувь, зочид буудлын хоногийн хөлс 13.5 хувь, оюутны дотуур байрны төлбөр 18.2 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. |
| Бусад бараа, үйлчилгээ | 6.0 | Бусад бараа, үйлчилгээний үнийн өсөлт нь үсчин гоо сайхны үйлчилгээний дэд бүлгийн үнэ 14.5 хувь, гоо сайхан, ариун цэврийн барааных 3.7 хувь, бугуйн цагны үнэ 33.1 хувь, алтан бөгжнийх 39.7 хувь, мөнгөн аяганых 40.0 хувиар өссөнөөс шалтгаалжээ. |

## Мал аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Мал аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2012 оны 12 дугаар сард үхрийн 2 м-ээс дээш урттай ширний дундаж үнэ Увс, Ховд, Дундговь, Баян-Өлгий, Баянхонгор, Хөвсгөл аймагт хамгийн бага буюу 25.0-30.0 мян.төг, Булган, Архангай, Орхон, Төв аймаг, Улаанбаатар хотод хамгийн их буюу 37.0-40.0 мян.төг, адууны ширнийх Увс, Говьсүмбэр, Дархан-Уул аймагт хамгийн бага буюу 28.0-34.0 мян.төг, Орхон, Сүхбаатар, Хэнтий, Баян-Өлгий, Төв, Өмнөговь, Баянхонгор аймагт хамгийн их буюу 42.0-50.0 мян.төг, ямааны 1 кг цагаан ноолуурын үнэ Сүхбаатар, Ховд, Орхон, Дархан-Уул, Өмнөговь аймагт хамгийн бага буюу 37.5-40.0 мян.төг, Завхан, Өвөрхангай, Говь-Алтай, Баян-Өлгий аймаг, Улаанбаатар хотод хамгийн их буюу 48.0-53.0 мян.төг байна.

Үхрийн 2 м-ээс дээш урттай ширний дундаж үнэ Төв, Архангай, Дархан-Уул, Сүхбаатар, Завхан аймагт өмнөх сарынхаас 0.5-8.0 мян.төг буюу 1.3-29.6 хувиар өсч, Баянхонгор, Ховд, Хөвсгөл, Дундговь аймагт 2.0-3.0 мян.төг буюу 6.3-10.7 хувиар буурч, Баян-Өлгий, Увс, Булган, Орхон, Өвөрхангай, Дорнод аймаг, Улаанбаатар хотод өмнөх сарын түвшинд байв.

Адууны ширний дундаж үнэ Баян-Өлгий, Орхон, Хөвсгөл, Хэнтий, Булган, Сүхбаатар, Өмнөговь, Төв, Дархан-Уул, Баянхонгор, Сэлэнгэ, Завхан аймагт өмнөх сарынхаас 1.0-12.0 мян.төг буюу 2.4-48.0 хувиар өсч, Говьсүмбэр, Увс аймаг, Улаанбаатар хотод өмнөх сарынхаас 1.0-7.0 мян.төг буюу 2.4-20.0 хувиар буурч, Ховд, Архангай, Өвөрхангай, Дорнод аймагт өмнөх сарын түвшинд байв.

Ямааны 1 кг цагаан ноолуурын дундаж үнэ Дундговь, Завхан, Говь-Алтай, Баян-Өлгий, Өвөрхангай аймаг, Улаанбаатар хотод өмнөх сарынхаас 0.5-8.0 мян.төг буюу 1.2-19.5 хувиар өсч, Сүхбаатар аймагт 5.0 мян. төг буюу 11.8 хувиар буурч, Ховд, Архангай, Баянхонгор, Орхон, Дархан-Уул, Өмнөговь аймагт өмнөх сарын түвшинд байв.

Зураг-II.9

**Ямааны 1 кг цагаан ноолуурын зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 12 дугаар сард, мян.төг**




**Адууны 1 ширхэг ширний зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 12 дугаар сард, мян.төг**



**Үхрийн 2 м-ээс дээш урттай ширний зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 12 дугаар сард, мян.төг**




**Хонины ноостой нэхийний зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 12 дугаар сард, мян.төг**




## Улаанбаатар хотод арилжаалагдсан барилгын гол нэрийн материалын дундаж үнэ

Улаанбаатар хотод 2012 оны 12 дугаар сард арилжаалагдсан эх орны үйлдвэрийн болон ОХУ, БНХАУ, ХБНГУ, БНСУ-д үйлдвэрлэсэн барилгын үндсэн 29 нэр төрлийн материалын дундаж үнийг мэдээнд хамрууллаа.

2012 оны 12 дугаар сарын үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад БНХАУ-д үйлдвэрлэсэн цонхны нөлөөгүй шилний үнэ 2.0 мян.төг буюу 13.3 хувиар буурчээ. Эх орны үйлдвэрийн хөнгөн бетоны үнэ 35.7 мян.төг буюу 31.0 хувь, шалны ховилгүй банзных 38.0 мян.төг буюу 26.8 хувь, палкных 5.0 мян.төг буюу 21.7 хувь, вакуум цонхных 10.0 мян.төг буюу 12.5 хувь, БНХАУ-д үйлдвэрлэсэн уян шүршүүрийн үнэ 7.0 мян.төг буюу 38.9 хувь, шаазан угаагуурынх 20.0 мян.төг буюу 33.3 хувь, тосон будагных 500 төг буюу 25.0 хувь, өдрийн суурьгүй гэрлийнх 400 төг буюу 20.0 хувь, 50 кг-ын савлагаатай цементнийх 1.5 мян.төг буюу 18.8 хувь, шахмал шалных 2.0 мян.төг буюу 16.7 хувь, төмөр хаалганых 22.0 мян.төг буюу 15.9 хувь, шаазан суултуурынх 10.0 мян.төг буюу 11.1 хувь, крантных 5.0 мян. төг буюу 11.1 хувь, хадаасных 200 төг буюу 8.0 хувь, дотор эмульснийх 500 төг буюу 7.7 хувиар өсчээ.

Мөн өмнөх сарынхтай харьцуулахад 2012 оны 12 дугаар сард БНСУ-д үйлдвэрлэсэн ханын цаасны үнэ 500 төг буюу 10.0 хувиар өссөн байна.

## Орон сууцны үнийн индекс

Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт орон сууцны үнэ 2012 оны 4 дүгээр улиралд 2011 оны эцсийнхээс 15.7 хувь, өмнөх улирлынхаас 6.8 хувиар өсчээ. Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн орон сууцны үнийн жилийн дундаж өсөлт 28.6 хувьтай байв.

Орон сууцны үнийг дүүргээр авч үзэхэд 2012 оны 4 дүгээр улиралд 2011 оны эцсийнхээс Сонгинохайрхан дүүрэгт (22.3%), Баянгол (19.2%), Чингэлтэйд (15.5%), Баянзүрх дүүрэгт (11.4%), Хан-Уулд (11.3%), Сүхбаатар дүүрэгт (10.7%) өсч, өмнөх улирлынхаас Баянголд (8.7%), Сонгинохайрхан дүүрэгт (7.7%), Хан-Уулд (6.7%), Чингэлтэйд (6.6%) Баянзүрх дүүрэгт (5.2%) Сүхбаатар дүүрэгт (4.6%) өссөн байна (Зураг II.10).

Зураг-II.10

**Улаанбаатар хотын орон сууцны үнийн индекс, төвийн 6 дүүргээр, 2012 оны 4 дүгээр улирлын байдлаар, хувиар**



1970 оноос өмнө ашиглалтанд оруулсан орон сууцны үнэ 2012 оны 4 дүгээр улиралд 2011 оны эцсийнхээс төвийн 6 дүүрэгт 9.7-27.2 хувиар нэмэгдсэн бөгөөд 1970-2001 онд ашиглалтад оруулсан орон сууцных 11.1-21.9 хувиар өсчээ. Мөн 2002 оноос хойш ашиглалтад оруулсан орон сууцны үнэ төвийн 6 дүүрэгт 5.2-25.2 хувиар өссөн байна.

1970 оноос өмнө ашиглалтад оруулсан орон сууцны үнэ 2012 оны 4 дүгээр улиралд өмнөх улирлынхаас төвийн 6 дүүрэгт 1.5-9.6 хувиар нэмэгдсэн бөгөөд 1970-2001 онд ашиглалтад оруулсан орон сууцных 6.8-11.4 хувиар өсчээ. Мөн 2002 оноос хойш ашиглалтад оруулсан орон сууцны үнэ төвийн 6 дүүрэгт 1.3-11.0 хувиар нэмэгдсэн байна.

## II.3 Мөнгө, зээл, үнэт цаас

Мөнгөний нийлүүлэлт (М2) 2012 оны 12 дугаар сарын эцэст 7617.2 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 584.0 тэрбум төг буюу 8.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 1204.9 тэрбум төг буюу 18.8 хувиар өсчээ (Хүснэгт II.2).

Мөнгөний нийлүүлэлтийн бүтцийн хувьд 2012 оны 12 дугаар сарын эцэст 45.8 хувийг төгрөгийн хадгаламж, 18.8 хувийг гадаад валютын хадгаламж, 16.2 хувийг төгрөгийн харилцах, 11.3 хувийг гадаад валютын харилцах, 7.9 хувийг банкнаас гадуурх мөнгө эзэлж байна (Зураг II.11). Мөнгөний нийлүүлэлтэд төгрөгийн харилцахын эзлэх хувь өмнөх сарынхаас 1.1 пункт, төгрөгийн хадгаламжийнх 0.8 пункт, банкнаас гадуурх мөнгөнийх 0.8 пунктээр өсч, харин гадаад валютын хадгаламжийнх 1.5 пункт, гадаад валютын харилцахынх 1.2 пунктээр буурчээ.

Бага мөнгө 2012 оны 12 дугаар сарын эцэст 1835.3 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 278.2 тэрбум төг буюу 17.9 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 94.2 тэрбум төг буюу 5.4 хувиар өсчээ.

Иргэд, байгууллагын нийт хадгаламж 2012 оны 12 дугаар сарын эцэст 4922.8 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 325.8 тэрбум төг буюу 7.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 1032.5 тэрбум төг буюу 26.5 хувиар өсчээ. Төгрөгийн хадгаламж 2012 оны 12 дугаар сарын эцэст 3488.0 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 323.3 тэрбум төг буюу 10.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 575.6 тэрбум төг буюу 19.8 хувиар өсөв. Гадаад валютын хадгаламж 2012 оны 12 дугаар сарын эцэст 1434.7 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 2.3 тэрбум төг буюу 0.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 456.8 тэрбум төг буюу 46.7 хувиар өслөө (Хүснэгт II.2).

Зураг-II.11

**Мөнгөний нийлүүлэлт (М2), хэрэглээний үнийн улсын индексийн өөрчлөлт, сарын эцэст, хувиар, (өмнөх сар=100)**




Хүснэгт-II.2

**Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст, тэрбум төг**

| Үзүүлэлт | 2011 XII | 2012 XI | 2012 XII |
|---|---|---|---|
| **Мөнгөний нийлүүлэлт М2** | **6 412.3** | **7 033.2** | **7 617.2** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | 37.0 | 15.0 | 18.8 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 4.9 | - 1.4 | 8.3 |
| **Нийт хадгаламж** | **3 890.3** | **4 597.0** | **4 922.8** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | 41.1 | 20.5 | 26.5 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 2.0 | - 1.4 | 7.1 |
| **Төгрөгийн хадгаламж** | **2 912.4** | **3 164.7** | **3 488.0** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | 45.5 | 12.6 | 19.8 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 3.7 | - 0.3 | 10.2 |
| **Валютын хадгаламж** | **977.9** | **1 432.4** | **1 434.7** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | 29.6 | 42.5 | 46.7 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | - 2.7 | - 3.7 | 0.2 |

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2012 оны 12 дугаар сарын эцэст 828.5 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 106.4 тэрбум төг буюу 14.7 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 115.1 тэрбум төг буюу 16.1 хувиар өсчээ.

Нөөц мөнгө (М0) 2012 оны 12 дугаар сарын эцэст 2166.2 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 58.5 тэрбум төг буюу 2.6 хувиар буурлаа. Нөөц мөнгөний бүрэлдэхүүн хэсэг болох банкуудын харилцах, хадгаламж 2012

оны 12 дугаар сарын эцэст өмнөх сарынхаас 164.8 тэрбум төг буюу 11.0 хувиар буурч, 1340.0 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Банкуудын нийт актив 2012 оны 12 дугаар сарын эцэст 10727.5 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 810.6 тэрбум төг буюу 8.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2074.8 тэрбум төг буюу 24.0 хувиар өслөө.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2012 оны 12 дугаар сарын эцэст 6990.5 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 122.7 тэрбум төг буюу 1.8 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 1349.3 тэрбум төг буюу 23.9 хувиар өсчээ (Хүснэгт II.3).

Зээлийн өрийн үлдэгдлийг эзэмшигчээр нь авч үзэхэд 2012 оны 12 дугаар сарын эцэст нийт зээлийн 3827.7 тэрбум төг буюу 54.8 хувь нь хувийн секторт, иргэдэд 3099.6 тэрбум төг буюу 44.3 хувь нь, улсын байгууллагад 42.0 тэрбум төг буюу 0.6 хувь нь, бусад байгууллагад 11.6 тэрбум төг буюу 0.2 хувь нь, 9.7 тэрбум төг буюу 0.1 хувь нь бусад санхүүгийн байгууллагад ногдож байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2012 оны 12 дугаар сарын эцэст 295.1 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 3.4 тэрбум төг буюу 1.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 34.9 тэрбум төг буюу 10.6 хувиар буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.2 хувийг эзэлж, өмнөх сарынхаас 0.1 пункт, өмнөх оны мөн үеийнхээс 1.6 пунктээр буурчээ (Хүснэгт II.3).

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2012 оны 12 дугаар сарын эцэст 110.6 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 37.1 тэрбум төг буюу 25.1 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 36.9 тэрбум төг буюу 50.1 хувиар өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.6 хувийг эзэлж байгаа нь өмнөх сарынхаас 0.6 пунктээр буурч, өмнөх оны мөн үеийнхээс 0.3 пунктээр өссөн байна (Хүснэгт II.3).

Энэ оны 12 дугаар сарын эцэст аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдлийн 67.5 хувь нь ХААН банк, Голомт банк, Худалдаа, хөгжлийн банканд ногдож байна.

Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2012 оны 11 дүгээр сарын эцэст өмнөх сарынхаас 0.1 пунктээр буурч, өмнөх оны мөн үеийнхээс 2.5 пунктээр өсч, жилийн

Зураг-II.12

**Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц, хувиар, жил бүрийн 12 дугаар сарын эцсийн байдлаар**




Зураг-II.13

**Мөнгөний нийлүүлэлт (М2), бага мөнгө (М1) болон бараг мөнгөний өөрчлөлт, сарын эцэст, хувиар, (өмнөх оны мөн үе=100)**




Эх үүсвэр: *Монголбанкны статистикийн сарын бюллетень

Хүснэгт-II.3

**Зээлийн өрийн үлдэгдэл, чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл сарын эцэст, тэрбум төг**

| Үзүүлэлт | 2011 XII | 2012 XI | 2012 XII |
|---|---|---|---|
| **Зээлийн өрийн үлдэгдэл** | **5 641.2** | **6 867.8** | **6 990.5** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | 72.8 | 26.3 | 23.9 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 3.7 | 0.2 | 1.8 |
| **Чанаргүй зээл** | **330.0** | **298.5** | **295.1** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | - 11.9 | - 13.0 | - 10.6 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | - 3.8 | - 2.5 | - 1.1 |
| **Хугацаа хэтэрсэн зээл** | **73.7** | **147.7** | **110.6** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | - 18.6 | 106.5 | 50.1 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 3.1 | 11.5 | - 25.1 |
| **Зээлийн өрийн үлдэгдэлд чанаргүй зээлийн эзлэх хувь** | **5.8** | **4.3** | **4.2** |
| **Зээлийн өрийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь** | **1.3** | **2.2** | **1.6** |

хүү 18.6 хувь болжээ. Валютын зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх сарынхаас 1.1 пунктээр буурч, өмнөх оны мөн үеийнхээс 1.1 пунктээр өсч, жилийн хүү 13.3 хувь боллоо (Зураг II.14).

Гадаад валютын цэвэр албан нөөц 2012 оны 12 дугаар сарын эцэст өмнөх сарынхаас 1402.8 сая ам.доллар, өмнөх оны мөн үеийнхээс 1355.2 сая ам.доллараар нэмэгдэж, 3629.2 сая ам.долл болсон нь манай улсын импортын 28.2 долоо хоног буюу 7.1 сарын хэрэгцээг хангахаар байна (Зураг II.15).

## Үнэт цаасны зах зээл

Үнэт цаасны арилжаа 2012 оны 12 дугаар сард 20 өдөр явагдаж, 1.1 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 1.5 сая ш үнэт цаас арилжигдсан байна. Гүйлгээний хэмжээ 2012 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 692.4 тэрбум төг буюу 2.6 дахин өсч, өмнөх оны мөн үеийнхээс 7.9 тэрбум төг буюу 8.1 дахин буурчээ. Арилжсан үнэт цаасны тоо 2012 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 696.1 мян ш буюу 1.9 дахин өсч, өмнөх оны мөн үеийнхээс 4.1 сая ш буюу 3.8 дахин буурлаа.

Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2012 оны 12 дугаар сард 16839.1 болж, өмнөх сарынхаас 1242.5 нэгжээр өсчээ (зураг II.16). Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2012 оны 12 дугаар сард 1799.9 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 211.1 тэрбум төгрөг буюу 13.3 хувиар өслөө (Зураг II.17).

“НАКО ТҮЛШ” хувьцаат компаний 315.8 мянган ш хувьцаа 2012 оны 12 дугаар сард арилжигдсан нь хамгийн идэвхитэй арилжаалсан үнэт цаас байв.

## Валютын ханш

Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 12 дугаар сард 1396.1 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 21.9 төг буюу 1.6 хувиар суларсан байна (Хүснэгт II.4). Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас 0.7 хувиар

*Эх үүсвэр:* Монголбанкны статистикийн сарын бюллетень*

Зураг-II.14
**Чанаргүй зээл, сарын эцэст, тэрбум төг**




Зураг-II.15
**Зээлийн жилийн хүү, сарын эцэст, хувиар**




Зураг-II.16
**Гадаад валютын цэвэр албан нөөц, сарын эцэст, сая ам.долл**




Зураг-II.17
**ТОП-20 индекс, сарын дундаж, хувиар**



Зураг-II.18
**Зах зээлийн үнэлгээ, сарын эцэст, тэрбум төг**



суларч, 2012 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 0.02 хувиар чангарчээ (Зураг II.19).

Төгрөгийн евротой харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 12 дугаар сард 1830.6 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 19.0 төг буюу 1.0 хувиар суларчээ (Хүснэгт II.3). Төгрөгийн евротой харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас 0.3 хувиар чангарч, 2012 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 2.1 хувиар суларсан байна (Зураг II.20).

Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 12 дугаар сард 224.0 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 7.5 төг буюу 3.5 хувиар суларчээ (Хүснэгт II.4). Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас 1.2 хувиар суларч, 2012 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас өөрчлөгдөөгүй байна (Зураг II.21).

Төгрөгийн рубльтэй харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 12 дугаар сард 45.4 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 1.7 төг буюу 3.9 хувиар суларчээ (Хүснэгт II.4). Төгрөгийн рубльтэй харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас 0.2 хувиар чангарч, 2012 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 2.0 хувиар суларлаа (Зураг II.22).

Хүснэгт-II.4

**Монголбанкны төгрөгийн гадаад валюттай харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг**

| Үзүүлэлт | 2011 XII | 2012 XI | 2012 XII |
|---|---|---|---|
| **Ам. Доллар** | **1 374.2** | **1 396.4** | **1 396.1** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | 11.4 | 5.5 | 1.6 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 3.8 | 0.7 | 0.0 |
| **Евро** | **1 811.6** | **1 793.2** | **1 830.6** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | 11.1 | 0.0 | 1.0 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 1.0 | - 0.3 | 2.1 |
| **Юань** | **216.5** | **224.0** | **224.0** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | 16.6 | 7.6 | 3.5 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 4.0 | 1.2 | 0.0 |
| **Рубль** | **43.7** | **44.5** | **45.4** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | 9.3 | 3.8 | 3.9 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 1.9 | - 0.2 | 2.0 |

Зураг-II.19

**Төгрөгийн ам. доллартай харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг**




Зураг-II.20

**Төгрөгийн евротой харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг**




Зураг-II.21

**Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг**




Зураг-II.22

**Төгрөгийн рубльтэй харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг**



## II.4. Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн нийт хэмжээ 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4880.9 тэрбум төг, зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 6043.9 тэрбум төгрөг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1163.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Өмнөх оныхоос улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 393.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд зарлагын өсөлт орлогын өсөлтөөс 5.5 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ (Зураг II.23).

Улсын нэгдсэн төсвийн урсгал орлого 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4840.8 тэрбум төг, урсгал зардал 4590.1 тэрбум төг болж, тэнцвэржүүлсэн урсгал тэнцэл 250.6 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ. Өмнөх оныхоос урсгал орлого 627.1 тэрбум төг буюу 14.9 хувь, урсгал зардал 1353.7 тэрбум төг буюу 41.8 хувиар өсөв.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2012 оны 2, 3, 5, 6, 7, 9, 10, 11, 12 дугаар сарууддад 21.1-456.3 тэрбум төгрөгийн алдагдалтай, харин 1, 4, 8 дугаар сарууддад 8.0-116.5 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Төсвийн тэнцвэржүүлсэн урсгал тэнцэл 2012 оны 5 дугаар сард 197.3 тэрбум төг, 11 дүгээр сард 27.1 тэрбум төг, 12 дугаар сард 204.0 тэрбум төгрөгийн алдагдалтай, харин бусад сард 33.5-179.0 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа (Зураг II.24).

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн нийт хэмжээ 2012 оны 12 дугаар сард 558.8 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 179.3 тэрбум төг буюу 47.2 хувь, өмнөх оныхоос 53.1 тэрбум төг буюу 10.5 хувиар өссөн байна. Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2012 оны 12 дугаар сард 1015.1 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 507.9 тэрбум төг буюу 2 дахин өсч, өмнөх оныхоос 168.6 тэрбум төг буюу 14.2 хувиар буурчээ.

### Төсвийн орлого

Улсын нэгдсэн төсөвт 2012 урьдчилсан гүйцэтгэлээр 4968.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь өмнөх оныхоос 500.1 тэрбум төг буюу 11.2 хувиар өссөн байна.

Татварын нийт орлого өмнөх оныхоос 533.4 тэрбум төг буюу 14.5 хувиар нэмэгдэхэд

Зураг-II.23

**Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн эцсийн байдлаар, тэрбум төг**




Зураг-II.24

**Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн болон тэнцвэржүүлсэн урсгал тэнцэл, сараар, сая төг**



гадаад худалдааны татварын орлого 10.1 тэрбум төг буюу 3.0 хувиар буурсан хэдий ч нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 212.9 тэрбум төг буюу 45.0 хувь, дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого 198.8 тэрбум төг буюу 13.9 хувь, бусад татварын орлого 91.0 тэрбум төг буюу 15.9 хувь, орлогын албан татварын орлого 36.2 тэрбум төг буюу 4.3 хувь, өмчийн татварын орлого 4.5 тэрбум төг буюу 26.2 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Татварын бус орлого өмнөх оныхоос 93.7 тэрбум төг буюу 17.2 хувиар нэмэгдэхэд төсөвт газрын өөрийн орлого 41.8 тэрбум төг буюу 17.9 хувиар буурсан хэдий ч хувьцааны ногдол ашгийн орлого 66.8 тэрбум төг буюу 75.5 хувь, газрын тосны орлого 32.5 тэрбум төг буюу 42.8 хувь, хүү, торгуулийн орлого 20.7 тэрбум төг буюу 35.7 хувь, бусад нэр заагдаагүй орлого 11.9 тэрбум төг буюу 22.8 хувь, навигацын орлого 3.6 тэрбум төг буюу 10.2 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 84.6 хувийг татварын орлого, 12.9 хувийг татварын бус орлого, 1.8 хувийг тогтворжуулалтын сангийн орлого, 0.4 хувийг тусламжийн орлого, 0.3 хувийг хөрөнгийн орлого, эзэлж байгаа нь өмнөх оныхоос татварын орлогынх 2.5 пункт, татварын бус орлогынх 0.7 пункт, тусламжийн орлогынх 0.4 пунктээр өсч, тогтворжуулалтын сангийн орлогынх 3.6 пунктээр буурчээ (Хавсралт 5).

## II.5. Гадаад худалдаа

Монгол Улс 2012 онд дэлхийн 146 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт урьдчилсан дүнгээр 11123.5 сая ам.долл, үүнээс экспорт 4384.6 сая ам.долл, импорт 6738.9 сая ам.долларт хүрчээ. (Зураг II.25). Нийт бараа эргэлт өмнөх оныхоос 292.4 сая.ам.доллараар, экспорт 432.9 сая ам.доллараар буурч, импорт 140.5 сая ам.доллараар нэмэгджээ.

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2011 онд 2010 оныхоос 86.9 хувь, экспорт 65.6 хувь, импорт 106.2 хувь, 2012 онд 2011 оныхоос импорт 2.1 хувиар өсч, нийт бараа эргэлт 2.6 хувь, экспорт 9.0 хувиар буурсан байна.

2010 онд гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 56.3 хувь нь БНХАУ-д, 18.5 хувь нь ОХУ-д, үлдсэн 25.2 хувь нь бусад

## Төсвийн зарлага

Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр 6043.9 тэрбум төг болж, өмнөх оныхоос 1046.9 тэрбум төг буюу 20.9 хувиар нэмэгдсэн нь эргэж төлөгдөх цэвэр зээл 410.4 тэрбум төг буюу 85.5 хувиар буурсан хэдий ч бараа, үйлчилгээний зардал 705.2 тэрбум төг буюу 46.9 хувь, татаас ба шилжүүлгийн зардал 559.4 тэрбум төг буюу 33.0 хувь, хөрөнгийн зардал 103.5 тэрбум төг буюу 8.1 хувь, зээлийн үйлчилгээний төлбөрийн зардал 89.1 тэрбум төг буюу 3.4 дахин өссөнөөс шалтгаалжээ.

Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дүнд урсгал зардал 76.0 хувь, хөрөнгийн зардал 22.9 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл 1.1 хувийг эзэлж байгаа нь өмнөх оныхоос урсгал зардлын эзлэх хувь 11.2 пунктээр өсч, эргэж төлөгдөх цэвэр зээлийнх хувь 8.5 пункт, хөрөнгийн зардлынх 2.7 пунктээр буурчээ (Хавсралт 5).

## Хөрөнгийн зардал

Хөрөнгийн зардалд 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1384.4 тэрбум төг зарцуулсан нь өмнөх оныхоос 103.5 тэрбум төг буюу 8.1 хувиар нэмэгджээ. Энэ нь өмнөх оныхоос гадаадын эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн зардал 8.0 тэрбум төг буюу 4.7 хувиар буурч, дотоодын эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн зардал 111.5 тэрбум төг буюу 10.0 хувиар өссөнөөс шалтгаалсан байна.

Зураг-II.25

**Гадаад худалдааны нийт бараа эргэлт, жил бүрийн эцсийн байдлаар, сая ам.долл**



улсад, 2011 онд нийт бараа эргэлтийн 56.6 хувь нь БНХАУ-д, 15.1 хувь нь ОХУ-д, үлдсэн 28.3 хувь нь бусад улсад ногдож байсан бол 2012 онд урьдчилсан дүнгээр нийт бараа эргэлтийн 53.2 хувь нь БНХАУ-д, 17.3 хувь нь ОХУ-д, 29.5 хувь нь бусад улсад ногдож байна. БНХАУ-тай хийсэн бараа эргэлтийн эзлэх хувь 2012 онд өмнөх оныхоос 3.4 пунктээр буурч, ОХУ-тай хийсэн бараа эргэлтийн эзлэх хувь 2.2 пункт, бусад улсынх 1.1 пунктээр өсчээ.

Гадаад худалдааны нийт бараа эргэлтийг сараар авч үзэхэд 2010 оны 12 дугаар сард хамгийн их буюу 686.8 сая ам.долл, 2011 оны мөн 12 дугаар сард 1189.3 сая ам.долларт хүрч байсан бол 2012 оны 6 дугаар сард хамгийн их буюу 1219.5 сая ам.долларт хүрчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2011 онд 1780.9 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ өмнөх оныхоос 1489.3 сая ам.долл буюу 6.1 дахин нэмэгдэж байсан бол 2012 оны урьдчилсан дүнгээр 2354.3 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оныхоос 573.4 сая ам.долл буюу 32.2 хувиар өсчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2010 оны 12 дугаар сард 28.9 сая ам.долл, ашигтай гарч байсан бол 2011 оны 12 дугаар сард 72.8 сая ам.долл, 2012 оны 12 дугаар сард урьдчилсан дүнгээр 115.1 сая ам.долларын алдагдалтай гарчээ.

Зураг-II.26

**Гадаад худалдааны нийт бараа эргэлт, сараар, сая ам.долл**




Зураг-II.27

**Экспортын бүтэц, голлох улсаар, хувиар, 2012 оны эцсийн байдлаар**




## Экспорт

Монгол Улс 2012 онд урьдчилсан байдлаар нийт 58 оронд бараа, бүтээгдэхүүн экспортолсноос БНХАУ-д 92.6 хувь, ОХУ-д 1.8 хувь, Канад улсад 2.7 хувь, Итали улсад 0.7 хувь, БНСУ-д 0.3 хувь, ХБНГУ-д 0.4 хувь, Их Британи улсад 0.3 хувь, Щвейцарь 0.2 хувь, АНУ болон Франц, Япон улсад тус тус 0.1 хувь ногдож байгаа нь нийт экспортын 99.2 хувийг эзэлж байна (Зураг II.26).

Эрдэс бүтээгдэхүүний экспорт 2010 онд нийт экспортод 81.0 хувь, 2011 онд 89.2 хувь, 2012 онд урьдчилсан дүнгээр 89.2 хувийг эзэлж байна.

Экспортын 98.6 хувийг эрдэс бүтээгдэхүүн, нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл, мал, амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн эзэлж байна (Зураг II.27).

Экспортын хэмжээ 432.9 сая ам.доллараар буурахад үнэт ба хагас үнэт чулуу, металл, гоёлын зүйлсийн экспорт өмнөх оныхоос 12.4 сая ам.доллараар өссөн хэдий ч эрдэс бүтээгдэхүүний экспорт 389.6 сая ам.долл, нэхмэл бүтээгдэхүүнийх 7.9 сая ам.долл, мал, амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүнийх 15.7 сая ам.долл, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэлийнх 20.6 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлжээ.

Экспортод нүүрс 43.4 хувь, зэсийн баяжмал 19.1 хувь, төмрийн хүдэр 12.1 хувь, боловсруулаагүй газрын тос 7.7 хувь, цайрын хүдэр, баяжмал 3.0 хувь, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт 2.8 хувь, жоншны хүдэр, баяжмал 2.3 хувь, самнасан ноолуур 1.1 хувь, бусад бүтээгдэхүүн 8.5

хувийг эзэлж байна.

Нийт экспортод эзлэх хувь өмнөх оныхоос зэсийн баяжмалынх 1.0, самнасан ноолуурынх 0.1 нүүрс 3.8 пунктээр буурч, харин боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтных 0.5, жоншны хүдэр, баяжмалынх 0.4, төмрийн хүдрийнх 3.0 боловсруулаагүй газрын тосных 2.4 пунктээр нэмэгджээ.

Нүүрсний экспорт 2010 онд 16.7 сая т, нийт экспортод 30.3 хувь, 2011 онд 21.3 сая т, нийт экспортод 47.2 хувь, 2012 онд 20.9 сая т, нийт экспортод 43.4 хувийг эзэлж байна.

## Импорт

Монгол Улс 2012 онд урьдчилсан дүнгээр нийт 140 оронтой импортын худалдаа хийсний 27.6 хувийг БНХАУ-тай, 27.4 хувийг ОХУ-тай, 8.0 хувийг АНУ-тай, 7.4 хувийг Япон улстай, 6.9 хувийг БНСУ-тай, 3.7 хувийг ХБНГУ-тай, 1.0 хувийг Украин улстай, 1.4 хувийг Канад улстай хийсэн нь нийт импортын 83.4 хувийг эзэлж байна (Зураг II.28).

Нийт импортод АНУ-ын эзлэх хувь өмнөх оныхоос 0.2, ХБНГУ-ынх , Канад улсынх тус бүр 0.5, Украин улсынх 1.3, БНХАУ-ынх 3.0 пунктээр буурч, харин ОХУ-ынх 2.8, БНСУ-ынх 1.5 пунктээр өсчээ.

Өмнөх оныхоос импортын хэмжээ 140.5 сая ам.доллараар нэмэгдэхэд, эрдэс бүтээгдэхүүний импорт 308.0 сая ам.долл, хүнсний бэлэн бүтээгдэхүүн 64.8 сая ам.долл, хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн 42.2 сая ам.долл, үйлдвэрлийн төрөл бүрийн бараа 26.3 сая ам.долл, чулуун зүйлс, шил, шилэн сав 24.6 сая ам.долл, мал, амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн 14.6 сая ам.долл, хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэл 7.7 сая ам.долл, нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн 6.1 сая ам.долл, ургамлын гаралтай бүтээгдэхүүн 5.9 сая ам.доллараар өссөн нь нөлөөлжээ.

Нийт импортын 24.5 хувийг машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн эд анги, сэлбэг, 18.9 хувийг авто, агаар, усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги, 23.5 хувийг эрдэс бүтээгдэхүүн, 8.7 хувийг үндсэн төмөрлөг түүгээр хийсэн бүтээгдэхүүн, 5.9 хувийг хүнсний бэлэн бүтээгдэхүүн, 4.4 хувийг хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн, 3.5 хувийг хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэл, үлдсэн 10.5 хувийг бусад бүлгийн бүтээгдэхүүн эзэлж байна (Зураг II.29).

Зураг-II.28

**Экспортын бүтэц, барааны голлох бүлгээр, жил бүрийн эцсийн байдлаар, хувиар**




Хүснэгт-II.5

**Экспортолсон зарим эрдэс бүтээгдэхүүн, жил бүрийн эцсийн байдлаар, мян.т**

| | 2010 | 2011 | 2021* |
|---|---|---|---|
| Нүүрс | 16 726.2 | 21 296.0 | 20 915.5 |
| Зэсийн баяжмал | 568.7 | 575.9 | 574.5 |
| Боловсруулаагүй газрын тос | 2 070.8 | 2 553.7 | 3 568.0 |
| Цайрын баяжмал | 119.8 | 121.2 | 140.9 |
| Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт | 5.1 | 2.6 | 2.8 |
| Бусад | 3.7 | 2.0 | 1.8 |

Зураг-II.29

**Импортын бүтэц, голлох улсаар, хувиар, 2012 оны эцсийн байдлаар**



Импортолсон цахилгаан эрчим хүчний биет хэмжээ өмнөх оныхоос 90.5 сая квт.цаг, харин үнийн дүн 7.0 сая ам.долл, автобензиний биет хэмжээ 63.7 мян.т, үнийн дүн 124.0 сая ам.доллараар өсч, харин суудлын автомашины биет хэмжээ 11.1 мян.ш, үнийн дүн 17.5 сая ам.долл, гурилын биет хэмжээ 17.6 мян.т, үнийн дүн 7.5 сая ам.доллараар буурчээ (Зураг II.30).

Газрын тосны бүтээгдэхүүний импорт 2012 онд урьдчилсан дүнгээр 1163.8 мян.т буюу 1393.5 сая ам.долл болж, нийт импортын үнийн дүнгийн 20.7 хувийг эзэлж байна. Газрын тосны бүтээгдэхүүний импорт өмнөх оныхоос 137.3 мян.т буюу 13.4 хувиар нэмэгдэв.

Газрын тосны бүтээгдэхүүнийг 2012 онд урьдчилсан дүнгээр ОХУ, БНХАУ, БНСУ-аас, гурилыг БНХАУ болон ОХУ, Казахстан улсаас, цагаан будааг БНХАУ, БНСУ, ОХУ-аас, элсэн чихрийг Тайланд, ХБНГУ, Австрали, улсаас, нийтийн тээврийн хэрэгслийг БНСУ, ОХУ-аас, суудлын автомашиныг Япон, БНСУ, ХБНГУ, Их Британи улс, АНУ-аас, ачааны автомашиныг БНХАУ, АНУ, БНСУ, Белорусь, Энэтхэг улсаас голлон нийлүүлсэн байна.

Импортолсон барааны 87.5 хувийг валютын төлбөртэй худалдаа, 10.4 хувийг гадаадын хөрөнгө оруулалтын бараа, 1.9 хувийг тусламжийн бараа, 0.2 хувийг бусад төрлийн худалдаа эзэлж байна. Өмнөх оныхоос валютын төлбөртэй худалдааных 8.3, пунктээр өсч, харин гадаадын тусламжийн барааных 0.3, хөрөнгө оруулалтын барааных 8.0 пунктээр буурчээ.

Зураг-II.30

**Импортын бүтэц, барааны голлох бүлгээр, жил бүрийн эцсийн байдлаар, хувиар**




Зураг-II.31

**Зарим барааны импорт, жил бүрийн эцсийн байдлаар, мян.ам.долл**




## III. Үйлдвэрлэл, үйлчилгээ

### III.1. Бизнес регистрийн сан

Аж ахуйн нэгж, байгууллагын регистрийн санд 2012 оны жилийн эцсийн байдлаар 90.5 мянган аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 51.9 мянга буюу 57.4 хувь нь үйл ажиллагаа явуулж байна. Бизнес регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын 33.1 мянга буюу 63.8 хувь нь Улаанбаатар хотод, 6.7 мянга буюу 12.9 хувь нь Төвийн бүс, 5.2 мянга буюу 10.0 хувь нь Хангайн бүс, 4.9 мянга буюу 9.4 хувь нь Баруун бүс, 2.0 мянга буюу 3.9 хувь нь Зүүн бүсэд ногдож байна.

Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо 2011 оныхоос 23.1 мянга буюу 34.3 хувь, үүний дотор үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо 3.9 мянга буюу 8.0 хувиар нэмэгдсэн байна.

Регистрийн санд 2012 оны жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулаагүй 38.6 мянган аж ахуйн нэгж, байгууллага байгаагийн 11.1 мянга буюу 28.7 хувь нь үйл ажиллагаагаа эхлээгүй, 20.3 мянга буюу 52.7 хувь нь түр зогссон, 6.5 мянга буюу 16.7 хувь нь хаяг тодорхойгүй буюу олдохгүй,720 буюу 1.9 хувь нь бүрэн зогссон аж ахуйн нэгж, байгууллагууд байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын 83.8 хувь нь 1-9 ажиллагчидтай, 7.2 хувь нь 10-19 ажиллагчидтай, 5.4 хувь нь 20-49 ажиллагчидтай, 3.6 хувь нь 50-иас дээш ажиллагчидтай байна. 2011 оныхтой харьцуулахад 1-9 ажиллагчтай аж ахуйн нэгж, байгууллагын хувийн жин 3.1 пункт, 50 ба түүнээс дээш ажиллагчидтайнх 0.1 пунктээр өсч,10-19 ажиллагчидтайнх 1.9 пункт, 20-49 ажиллагчтайнх 1.3 пунктээр буурчээ.

### III.2 Мал аж ахуй

Улсын хэмжээгээр 2012 оны эцэст 40.9 сая толгой мал, үүний дотор 2330.4 мян.адуу, 2584.6 мян.үхэр, 305.8 мян.тэмээ, 18141.4 мян. хонь, 17558.7 мян.ямаа тоологдов (Зураг III.1), (Хавсралт 17).

Малын нийт тоо өмнөх оныхоос 4.6 сая буюу 12.6 хувиар өссөний дотор адуу 217.5 мянга буюу 10.3 хувь, үхэр 244.9 мянга буюу 10.5 хувь, тэмээ 25.8 мянга буюу 9.2 хувь, хонь 2.5 сая буюу 15.8 хувь, ямаа 1.6 сая буюу 10.2 хувиар өсчээ (Хавсралт 17).

Нийт мал сүрэгт 2012 оны эцэст хонь 44.3 хувь, ямаа 42.9 хувь, үхэр 6.3 хувь, адуу 5.7 хувь, тэмээ 0.7 хувийг эзэлж, өмнөх оныхоос хонины эзлэх хувь 1.2 пунктээр өсч, харин адуу, тэмээ, үхэр, ямааных 0.1-1.0 пунктээр буурсан байна (Хавсралт 18).

Малын тоо 2012 оны эцэст өмнөх оныхоос 15 аймаг, Улаанбаатар хотод 5 төрөл дээрээ өсчээ. Өвөрхангай (545.0 мян), Архангай (418.9 мян), Баянхонгор (403.1 мян), Дундговь (323.3 мян), Говь-Алтай (297.7 мян) аймгуудад малын тоо хамгийн өндөр өсөлттэй байна (Хавсралт 17).

Хөвсгөл (3601.7 мян), Архангай (3043.2 мян), Төв (3244.7 мян), Өвөрхангай (2970.7 мян), Баянхонгор (2640.8 мян) аймгууд 2012 онд хамгийн олон мал тоолуулж эхний таван байранд орсон байна.

Адуун сүргийн тоогоор Төв, Архангай, Булган, Сүхбаатар, Хэнтий аймаг; үхэр сүргийн тоогоор Архангай, Хөвсгөл, Төв, Булган, Хэнтий аймаг; тэмээн сүргийн тоогоор Өмнөговь, Баянхонгор, Дорноговь, Говь-Алтай, Дундговь аймаг; хонин сүргийн тоогоор Архангай, Хөвсгөл, Төв, Булган, Өвөрхангай аймаг; ямаан сүргийн тоогоор Баянхонгор, Хөвсгөл, Өвөрхангай, Говь-Алтай, Төв аймаг эхний таван байранд орсон байна.

Улсын хэмжээгээр 2012 оны эцэст малтай 207.8 мян.өрх байгаагийн 146.1 мян. өрх нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг малчин өрх байна. Малчин нэг өрх 2012 онд дунджаар 4 ам бүлтэй байна (Хавсралт 13).

Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж буй малчдын тоо 2012 оны эцэст 289.6 мянга болж, 16-34 насны малчид 40.7 хувь, 35

Зураг-III.1

**Малын тоо, төрлөөр**




Зураг-III.2

**Нийт сүрэгт 5 хошуу малын эзлэх хувь**




Зураг-III.13

**Малын тоо, аймаг, нийслэлээр, 2012 оны байдлаар**



наснаас тэтгэвэрт гарах хүртэлх насны малчид 49.7 хувь, тэтгэврийн насны малчид 9.6 хувийг эзэлж байна (Хавсралт 14).

Малтай өрхийн тоо өмнөх оныхоос 1.9 хувиар, үүнээс 500 хүртэлх малтай өрхийн тоо 4.0 хувиар буурсан ч 500-аас дээш малтай өрхийн тоо 28.0 хувиар өссөн байна.

Улсын хэмжээгээр 2012 онд малтай нэг өрхөд ногдох малын тоо дунджаар 195 болж, өмнөх оныхоос 14.9 хувиар өслөө. Малтай нэг өрхөд 11 адуу, 12 үхэр, 1 тэмээ, 86 хонь, 84 ямаа ногдож байна. Өмнөх оныхоос малтай нэг өрхөд ногдох адуу, үхэр тус бүр 1, ямаа 9, хонь 13-аар өсч, харин тэмээний тоо өөрчлөгдөөгүй байна (Хавсралт 16).

Малтай өрхийн 43.8 хувь нь 100 хүртэл, 23.3 хувь нь 101-200, 24.3 хувь нь 201-500, 6.9 хувь нь 501-999, 1.7 хувь нь 1000-аас дээш тооны малтай байна.

Малтай нэг өрхөд ногдох малын тоо Архангай, Дорнод, Баянхонгор, Говь-Алтай, Өмнөговь, Төв, Дундговь, Сүхбаатар, Булган, Говьсүмбэр, Дорноговь, Хэнтий аймагт улсын дунджаас 2-100 толгойгоор илүү, бусад аймагт 2-134 толгойгоор бага байна.

Малчин өрхөд ногдох малын тоо 2012 оны эцэст 244 болж, өмнөх оныхоос 3.8 хувиар өслөө (Зураг III.6). Нийт малчин өрхийн 41.3 хувь нь Хангайн, 26.4 хувь нь Баруун, 20.0 хувь нь Төвийн, 11.2 хувь нь Зүүн бүсэд, 1.1 хувь нь Улаанбаатарт байна.

Улсын хэмжээнд 2012 оны байдлаар оны эхний эх малын 87.6 хувь буюу 13.7 сая эх мал төллөжээ (Хавсралт 21). Гүүний 77.9 хувь, үнээний 80.2 хувь, ингэний 55.9 хувь, эм хонины 90.9 хувь, эм ямааны 86.5 хувь нь төллөв. Төллөлтийн хувь өмнөх оныхоос 3.0 пунктээр өссөнөөс гүүнийх 1.5, үнээнийх 3.7, ингэнийх 7.2, эм хониных 4.1, эм ямааных 1.9 пунктээр дээгүүр байна.

2012 онд нийт гарсан төлийн 13.4 сая буюу 96.5 хувийг нь бойжуулсан нь өмнөх оныхоос 0.8 сая толгойгоор, төл бойжилтын хувь 1.6 пунктээр дээгүүр байна (Хавсралт 22). Унаганы 95.4 хувь, тугалны 96.9 хувь, ботгоны 97.6 хувь, хурганы 97.0 хувь, ишигний 96.1 хувь нь бойжиж, төл бойжилтын хувь бүх төрлөөр өмнөх оныхоос 0.7-1.9 пунктээр өслөө.

Зураг-III.4

**Малтай өрхийн тоо, малын тооны бүлэглэлтээр**




Зураг-III.5

**Малчин өрхийн тоо**




Зураг-III.6

**Нэг малчин болон малтай өрхөд ногдох мал**




Зураг-III.7

**Бойжсон төл**



Оны эхэнд тоологдсон нийт малын 1.2 хувь буюу 0.4 сая том мал 2012 онд зүй бусаар хорогдов. (Зураг III.8, Хавсралт 23).

Нийт хорогдсон малын 40.2 мян буюу 9.4 хувь нь өвчнөөр хорогдсон байна. Оны эхний малд хорогдлын эзлэх хувь Баруун бүсэд хамгийн их буюу 1.6 хувь, Зүүн бүсэд 1.3 хувь, Хангайн бүсэд 1.2 хувь, Төвийн бүсэд 0.7 хувь, Улаанбаатар хотод 0.8 хувь байна.

Хонин толгойд шилжүүлснээр хадлан, бэлчээрийн 100 га талбайд ногдох малын тоо 2012 онд 60 болж, өмнөх оныхоос 13.2 хувиар өслөө. Энэ үзүүлэлт Орхон аймагт 857, Улаанбаатар хотод 320, Дархан-Уул аймагт 269, Булган аймагт 179, Архангай аймагт 174, Сэлэнгэ 141, Хөвсгөл аймагт 137 толгой байгаа нь улсын дунджаас нилээд өндөр байна.

## III.3 Газар тариалан

Улсын хэмжээгээр 2012 оны байдлаар нийт 379.7 мян.га талбайд тариалалт хийснээс 306.2 мян.га-д үр тариа, 16.8 мян.га-д төмс, 7.9 мян.га-д хүнсний ногоо, 13.8 мян.га-д тэжээлийн ургамал, 35.1 мян.га-д техникийн ургамал, жимс, жимсгэнэ тариалсан нь өмнөх оныхоос нийт тариалсан талбай 33.8 мян.га-гаар буюу 9.8 хувь өссөн байна.

2012 онд 479.3 мян.т үр тариа, 245.9 мян.т төмс, 98.9 мян.т хүнсний ногоо хураaж, 1175.1 мян.т хадлан, 39.1 мян.т гар тэжээл бэлтгэсэн байна. Өмнөх оныхоос хураасан үр тариа 33.2 мян.т буюу 7.5 хувь, төмс 44.3 мян.т буюу 22.0 хувиар нэмэгдэж, харин хүнсний ногоо 56.3 т буюу 0.1 хувь, хадлан 20.1 мян.т буюу 1.7 хувь, гар тэжээл 7.7 мян.т буюу 16.4 хувиар буурсан байна.

Га тутмаас 15.7 цн үр тариа, 146.2 цн төмс хураасан нь өмнөх оныхоос үр тариа 0.8 цн буюу 5.4 хувь, төмс 15.1 цн буюу 11.5 хувиар их байна. Үр тарианы га-гийн ургац Сэлэнгэ, Төв, Баян-Өлгий, Орхон аймагт улсын дунджаас 1.5-7.9 центнерээр их, харин бусад аймагт 0.1-11.6 центнерээр бага байна.

Төмсний га-гийн ургац Сэлэнгэ, Төв аймагт улсын дунджаас 7.0-53.4 центнерээр их, харин нийслэл болон бусад аймагт 9.1-119.5 центнерээр бага байна.

Хураасан үр тарианы 50.2 хувь нь Сэлэнгэ, 22.5 хувь нь Төв, 9.6 хувь нь Булган, 3.9 хувь нь Хөвсгөл; төмсний 41.0 хувь нь Төв, 25.3 хувь нь Сэлэнгэ, 5.9 хувь нь Ховд, 5.8

Зураг-III.8

**Хорогдсон мал тоо**




Зураг-III.9

**100 га хадлан, бэлчээрийн талбайд ногдох мал**




Зураг III.10

**Хураасан үр тариа, мян.т жил бүрийн эцэст**




Зураг-III.11

**Хураасан төмс, хүнсний ногоо, мян.т жил бүрийн эцэст**



хувь нь Дархан-Уул, 3.6 хувь нь Булган аймагт ногдож байна.

Бүсээр авч үзэхэд хураасан үр тарианы 75.4 хувь нь Төвийн, 16.4 хувь нь Хангайн, 6.0 хувь нь Зүүн, 2.2 хувь нь Баруун бүсэд ногдож байна. Хураасан үр тарианы хэмжээ өмнөх оныхоос Төвийн бүсэд 17.9 мян.т буюу 5.2 хувь, Зүүн бүсэд 14.9 мян.т буюу 2.1 дахин, Баруун бүсэд 337.4 т буюу 3.3 хувь, Хангайн бүсэд 196.1 т буюу 0.2 хувиар өслөө.

Хураасан нийт хүнсний ногооны 35.1 хувь нь Сэлэнгэ аймагт, 13.1 хувь нь Дархан-Уул аймагт, Төв болон Ховд аймагт тус бүр 11.5 хувь, үлдсэн 28.8 хувь нь нийслэл болон бусад аймагт ногдож байна.

Бэлтгэсэн нийт хадлангийн 175.2 мян.т буюу 14.9 хувь нь Сэлэнгэ, 166.0 мян.т буюу 14.1 хувь нь Хөвсгөл, 135.4 мян.т буюу 11.5 хувь нь Хэнтий, 104.6 мян.т буюу 8.9 хувь нь Төв, 99.7 мян.т буюу 8.5 хувь нь Булган, 82.5 мян.т буюу 7.0 хувь нь Архангай, 71.7 мян.т буюу 6.1 хувь нь Дархан-Уул, 62.8 мян.т буюу 5.3 хувь нь Ховд, 58.4 мян.т буюу 5.0 хувь нь Баян-Өлгий аймагт, үлдсэн 218.8 мян.т буюу 18.7 хувь нь нийслэл болон бусад аймагт ногдож байна.

Зураг-III.12

| СЭ | 2 312.1 | 2 368.4 | 2 467.9 | 131 | 135 | 141 |
| ТӨ | 4 680.8 | 5 127.2 | 5 651.3 | 87 | 95 | 106 |
| | | | **Зүүн бүс** | | | |
| **Дүн** | **9 706.6** | **10 340.9** | **11 265.3** | **43** | **46** | **50** |
| ДД | 2 462.9 | 2 551.5 | 2 696.3 | 26 | 27 | 28 |
| СҮ | 3 478.4 | 3 718.9 | 4 092.1 | 46 | 48 | 53 |
| ХЭ | 3 765.2 | 4 070.5 | 4 476.8 | 70 | 75 | 83 |
| | | | **Улаанбаатар** | | | |
| **УБ** | **654.5** | **689.6** | **757.3** | **256** | **274** | **320** |

Хавсралт № 23

**Хураасан үр тариа, төмс, хүнсний ногоо, бэлтгэсэн өвс хадлан, тэжээл, бүс, аймаг, нийслэлээр, жилийн эцсийн байдлаар**

т

| Аймаг нийслэл | Үр тариа | | Төмс | | Хүнсний ногоо | | Бэлтгэсэн хадлан | | Бэлтгэсэн гар тэжээл | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2011 | 2012 | 2011 | 2012 | 2011 | 2012 | 2011 | 2012 | 2011 | 2012 |
| **Дүн** | **446 050.5** | **479 348.8** | **201 638.9** | **245 935.0** | **98 973.9** | **98 917.6** | **1 195 238.5** | **1 175 126.3** | **46 743.8** | **39 069.0** |
| **Баруун бүс** | | | | | | | | | | |
| **Дүн** | **10 266.6** | **10 604.0** | **25 683.8** | **26 938.8** | **16 671.8** | **18 788.0** | **220 209.0** | **197 897.5** | **14 929.7** | **12 335.6** |
| БӨ | 121.4 | 88.0 | 4 050.0 | 4 161.7 | 1 590.0 | 1 691.0 | 61 474.1 | 58 394.0 | 6 755.0 | 5 477.0 |
| ГО | 832.8 | 1 169.6 | 1 504.0 | 1 930.2 | 804.4 | 1 348.3 | 5 965.6 | 4 236.9 | 313.3 | 380.6 |
| ЗА | 1 005.8 | 1 320.0 | 3 533.5 | 3 187.0 | 2 129.1 | 1 807.9 | 28 563.7 | 20 486.3 | 1 444.4 | 823.5 |
| УВ | 7 860.3 | 7 622.6 | 2 581.8 | 3 100.9 | 1 746.2 | 2 592.2 | 53 095.0 | 51 944.8 | 2 524.0 | 1 937.0 |
| ХО | 446.3 | 403.8 | 14 014.5 | 14 559.0 | 10 402.1 | 11 348.6 | 71 110.6 | 62 835.5 | 3 893.0 | 3 717.5 |
| **Хангайн бүс** | | | | | | | | | | |
| **Дүн** | **78 485.3** | **78 681.4** | **26 246.3** | **25 218.8** | **13 090.3** | **12 936.2** | **441 842.3** | **395 273.5** | **11 661.2** | **10 420.8** |
| АР | 3 619.0 | 3 550.0 | 4 020.2 | 3 508.3 | 1 245.5 | 1 346.9 | 85 139.0 | 82 525.4 | 1 191.7 | 1 308.5 |
| БХ | 10.9 | 7.6 | 3 108.6 | 2 645.2 | 1 390.1 | 1 275.2 | 3 549.0 | 3 249.8 | 589.0 | 570.7 |
| БУ | 44 742.7 | 45 917.0 | 9 005.0 | 8 842.5 | 3 980.4 | 3 622.0 | 107 504.0 | 99 660.0 | 2 600.0 | 2 361.0 |
| ОР | 4 652.8 | 7 366.0 | 4 175.7 | 3 221.1 | 3 870.7 | 3 338.5 | 9 450.0 | 10 987.3 | 16.5 | 310.9 |
| ӨВ | 2 057.0 | 2 983.0 | 3 068.9 | 3 662.6 | 1 648.2 | 1 991.6 | 32 989.5 | 32 833.9 | 6 372.2 | 5 289.5 |
| ХӨ | 23 402.9 | 18 857.8 | 2 867.9 | 3 339.1 | 955.4 | 1 362.0 | 203 210.8 | 166 017.2 | 891.8 | 580.2 |
| **Төвийн бүс** | | | | | | | | | | |
| **Дүн** | **343 536.1** | **361 424.4** | **136 708.0** | **178 279.2** | **61 685.0** | **59 781.6** | **315 759.4** | **358 556.8** | **18 538.3** | **14 304.7** |
| ГС | - | - | 73.1 | 34.9 | 114.6 | 27.4 | 1 366.7 | 2 282.1 | 332.5 | 111.6 |
| ДА | 16 803.8 | 12 820.8 | 14 276.5 | 14 208.0 | 13 144.7 | 12 928.9 | 54 703.0 | 71 734.9 | 449.7 | 501.0 |
| ДО | - | - | 224.3 | 207.8 | 143.2 | 181.4 | 1 394.5 | 1 459.1 | 98.4 | 191.1 |
| ДУ | - | - | 174.4 | 121.7 | 34.5 | 29.9 | 106.9 | 25.0 | 4 059.5 | 3 613.0 |
| ӨМ | - | - | 743.7 | 636.8 | 518.7 | 474.4 | 3 561.1 | 3 265.4 | 439.9 | 762.7 |
| СЭ | 219 205.8 | 240 733.0 | 55 374.6 | 62 264.7 | 34 867.3 | 34 768.3 | 164 024.5 | 175 202.7 | 1 203.3 | 601.2 |
| ТӨ | 107 526.5 | 107 870.6 | 65 841.4 | 100 805.3 | 12 862.0 | 11 371.3 | 90 602.7 | 104 587.6 | 11 955.0 | 8 524.1 |
| **Зүүн бүс** | | | | | | | | | | |
| **Дүн** | **13 762.5** | **28 639.0** | **7 700.8** | **10 315.4** | **3 920.0** | **4 274.6** | **194 190.4** | **202 474.3** | **1 224.7** | **1 599.0** |
| ДД | 5 506.5 | 14 149.0 | 2 253.3 | 3 031.3 | 1 022.4 | 738.8 | 57 027.9 | 55 266.3 | 182.8 | 477.1 |
| СҮ | - | - | 647.5 | 683.2 | 212.1 | 223.1 | 10 962.5 | 11 765.0 | 729.2 | 731.0 |
| ХЭ | 8 256.0 | 14 490.0 | 4 800.0 | 6 600.9 | 2 685.5 | 3 312.7 | 126 200.0 | 135 443.0 | 312.7 | 390.9 |
| **Улаанбаатар** | | | | | | | | | | |
| **УБ** | **-** | **-** | **5 300.0** | **5 182.7** | **3 606.8** | **3 137.2** | **23 237.4** | **20 924.1** | **389.9** | **408.9** |

Хавсралт № 24

**Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, дэд салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн эцэст**

сая төг

| Аж үйлдвэрийн салбар | 2010 | 2011 | 2012 | 2012/2011 % |
|---|---|---|---|---|
| **Нийт дүн** | **1 874 578.2** | **2 058 961.3** | **2 206 772.2** | **107.2** |
| **Уул уурхай, олборлох аж үйлдвэр** | **1 099 379.2** | **1 203 899.8** | **1 291 235.1** | **107.3** |
| Нүүрс олборлолт | 264 511.6 | 324 165.6 | 299 239.3 | 92.3 |
| Газрын тос олборлолт | 119 352.2 | 139 463.0 | 198 941.3 | 142.6 |
| Металлын хүдэр олборлолт | 689 028.2 | 717 495.4 | 766 210.5 | 106.8 |
| Бусад ашигт малтмал олборлолт | 26 487.2 | 22 775.8 | 26 844.0 | 117.9 |
| **Боловсруулах аж үйлдвэр** | **560 676.8** | **628 083.7** | **678 785.4** | **108.1** |
| Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл | 282 614.7 | 312 340.0 | 345 277.3 | 110.5 |
| Тамхи үйлдвэрлэл | 20 597.9 | 25 544.9 | 21 071.9 | 82.5 |
| Нэхмэлийн үйлдвэрлэл | 100 052.5 | 101 786.5 | 82 332.5 | 80.9 |
| Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт | 7 866.5 | 14 655.4 | 14 134.1 | 96.4 |
| Арьс, шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл | 3 856.8 | 6 810.4 | 12 538.5 | 184.1 |
| Мод, модон эдлэл үйлдвэрлэл | 3 085.6 | 2 715.3 | 2 866.2 | 105.6 |
| Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 2 311.9 | 2 925.1 | 4 076.1 | 139.3 |
| Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа | 11 483.5 | 10 154.2 | 16 254.4 | 160.1 |
| Кокс, шахмал түлш үйлдвэрлэл | 292.9 | 392.7 | 1 376.1 | 350.4 |
| Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 15 475.3 | 22 561.8 | 22 526.3 | 99.8 |
| Резин болон хуванцар бүтээгдэхүүн | 450.2 | 2 643.7 | 9 935.9 | 375.8 |
| Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл | 39 643.4 | 55 705.7 | 68 331.4 | 122.7 |
| Төмрийн үйлдвэрлэл | 69 425.0 | 63 006.4 | 66 701.8 | 105.9 |
| Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл | 44.9 | 43.4 | 78.3 | 180.4 |
| Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл | 1 593.5 | 1 971.9 | 3 931.4 | 199.4 |
| Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл | 383.8 | 3 291.3 | 3 686.0 | 112.0 |
| Эмнэлгийн багаж хэрэгсэл, нарийн хэмжүүр, хараа зүйн хэрэгсэл үйлдвэрлэл | 321.5 | 69.4 | 8.7 | 12.5 |
| Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл | 58.0 | 496.9 | 776.5 | 156.3 |
| Тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад | 1 118.9 | 968.8 | 2 881.9 | 297.5 |
| **Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж** | **214 522.1** | **226 977.7** | **236 751.7** | **104.3** |
| Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл | 200 932.7 | 213 331.9 | 222 924.8 | 104.5 |
| Ус ариутгал, усан хангамж | 13 589.4 | 13 645.8 | 13 826.9 | 101.3 |

Хавсралт № 25

**Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн эцэст**

| Нэр төрөл | Хэмжих нэгж | 2010 | 2011 | 2012 | 2012/2011 % |
|---|---|---|---|---|---|
| Цахилгаан эрчим хүч | сая кВт.цаг | 3 654.2 | 3 902.0 | 4 096.3 | 105.0 |
| Дулааны эрчим хүч | мян.Гкал | 8 072.3 | 8 419.9 | 8 671.8 | 103.0 |
| Газрын тос | мян.баррел | 2 181.4 | 2 548.9 | 3 636.0 | 142.6 |
| Нүүрс | мян.т | 25 246.4 | 30 940.1 | 28 561.0 | 92.3 |
| Зэсийн баяжмал, 35%-ийн агуулгад шилжүүлснээр | мян.т | 357.1 | 347.4 | 347.6 | 100.1 |
| Молибдений баяжмал, 47%-ийн агуулгад шилжүүлснээр | т | 4 677.1 | 4 163.1 | 4 050.2 | 97.3 |
| Хайлуур жоншны баяжмал | мян.т | 140.7 | 116.4 | 157.2 | 135.1 |
| Алт | кг | 6 037.1 | 5 702.6 | 5 995.0 | 105.1 |
| Катодын зэс, 99% | т | 2 746.2 | 2 388.7 | 2 281.7 | 95.5 |
| Сүлжмэл эдлэл | мян.ш | 731.5 | 759.2 | 795.6 | 104.8 |
| Самнасан ноолуур | т | 824.7 | 874.3 | 417.0 | 47.7 |
| Хивс | мян.м2 | 609.6 | 850.8 | 915.8 | 107.6 |
| Тэмээний ноосон хөнжил | мян.м | 15.3 | 25.8 | 8.2 | 31.8 |
| Зүсмэл материал | м3 | 20 172.0 | 10 558.4 | 14 213.2 | 134.6 |
| Шохой | мян.т | 50.2 | 45.3 | 68.2 | 150.5 |
| Сонин | сая х.д.х | 42.2 | 40.8 | 69.2 | 169.5 |
| Малын мах | т | 12 022.7 | 13 164.6 | 13 158.9 | 100.0 |
| Хиаман төрлийн бүтээгдэхүүн | т | 1 734.8 | 2 204.4 | 2 222.7 | 100.8 |
| Гурил | т | 143 488.7 | 105 251.9 | 114 898.8 | 109.2 |
| Талх | т | 21 747.5 | 23 882.0 | 25 448.5 | 106.6 |
| Нарийн боов | т | 12 926.9 | 13 027.5 | 13 880.8 | 106.5 |
| Гоймон | т | 2 084.8 | 2 239.0 | 3 191.7 | 142.6 |
| Амтат ус, ундаа | мян.л | 67 904.4 | 75 842.3 | 74 552.4 | 98.3 |
| Архи, дарс | мян.л | 20 396.7 | 25 596.1 | 26 894.4 | 105.1 |
| Спирт | мян.л | 3 609.1 | 3 440.4 | 3 305.3 | 96.1 |

Хавсралт № 26

**Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн, салбараар, оны үнээр, жил бүрийн эцэст**

сая төг

| Аж үйлдвэрийн салбар | 2010 | 2011 | 2012 | Үүнээс: гадаадад | Дүнд эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2010 | 2011 | 2012 |
| **Аж үйлдвэр бүгд** | **4 468 170.3** | **5 626 746.2** | **6 058 023.8** | **3 957 990.3** | **100.0** | **100.0** | **100.0** |
| **Уул уурхай, олборлох аж үйлдвэр** | **3 154 684.7** | **3 651 166.3** | **3 654 047.4** | **3 220 635.5** | **70.6** | **64.9** | **60.3** |
| Нүүрс олборлолт | 1 104 889.6 | 1 434 851.4 | 1 064 740.9 | 915 557.6 | 24.7 | 25.5 | 17.6 |
| Газрын тос олборлолт | 209 244.7 | 303 813.8 | 456 283.9 | 456 283.9 | 4.7 | 5.4 | 7.5 |
| Металлын хүдэр олборлолт | 1 774 946.3 | 1 838 563.5 | 2 057 217.1 | 1 786 682.5 | 39.7 | 32.7 | 34.0 |
| Бусад ашигт малтмал олборлолт | 65 604.1 | 73 937.6 | 75 805.5 | 62 111.5 | 1.5 | 1.3 | 1.3 |
| **Боловсруулах аж үйлдвэр** | **940 056.5** | **1 566 825.2** | **1 949 749.9** | **737 354.8** | **21.0** | **27.8** | **32.2** |
| Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл | 493 317.5 | 664 855.2 | 719 877.8 | 5 554.0 | 11.0 | 11.8 | 11.9 |
| Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт | 44 490.4 | 42 978.5 | 67 618.3 | 4 746.1 | 9.0 * | 6.5 * | 9.4 * |
| Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 30 551.3 | 36 167.6 | 40 201.5 | - | 6.2 * | 5.4 * | 5.6 * |
| Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл үйлдвэрлэл | 85 133.6 | 140 111.8 | 60 905.3 | - | 17.3 * | 21.1 * | 8.5 * |
| Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 62 234.9 | 70 190.7 | 80 892.2 | - | 12.6 * | 10.6 * | 11.2 * |
| Ундаа үйлдвэрлэл /согтууруулах ундаа ороод/ | 270 907.4 | 375 406.6 | 470 260.5 | 807.9 | 54.9 * | 56.5 * | 65.3 * |
| Тамхи үйлдвэрлэл | 38 661.4 | 41 611.6 | 45 211.7 | - | 0.9 | 0.7 | 0.7 |
| Нэхмэлийн үйлдвэрлэл | 144 598.9 | 179 933.2 | 175 078.8 | 96 081.5 | 3.2 | 3.2 | 2.9 |
| Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт | 11 523.0 | 15 614.8 | 20 604.6 | 2 800.1 | 0.3 | 0.3 | 0.3 |
| Арьс, шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл | 1 499.1 | 2 451.5 | 8 565.1 | 5 504.1 | 0.0 | 0.0 | 0.1 |
| Мод, модон эдлэл үйлдвэрлэл | 8 808.0 | 11 500.9 | 15 660.5 | - | 0.2 | 0.2 | 0.3 |
| Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа | 16 036.6 | 16 752.8 | 26 519.4 | - | 0.4 | 0.3 | 0.4 |
| Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 10 380.6 | 11 772.9 | 14 935.0 | - | 0.2 | 0.2 | 0.2 |
| Кокс, шахмал түлш үйлдвэрлэл | 190.6 | 282 311.9 | 567 758.7 | 565 804.5 | 0.0 | 5.0 | 9.4 |
| Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 26 810.3 | 42 850.3 | 54 538.1 | - | 0.6 | 0.8 | 0.9 |
| Резин болон хуванцар бүтээгдэхүүн | 649.8 | 3 195.6 | 4 061.8 | - | 0.0 | 0.1 | 0.1 |
| Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл | 59 252.3 | 174 344.7 | 133 027.0 | - | 1.3 | 3.1 | 2.2 |
| Төмрийн үйлдвэрлэл | 107 344.9 | 91 011.5 | 123 990.4 | 61 106.6 | 2.4 | 1.6 | 2.0 |
| Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл | 14 386.1 | 22 461.5 | 28 050.8 | 488.9 | 0.3 | 0.4 | 0.5 |
| Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл | 1 142.0 | 1 405.4 | 3 841.5 | - | 0.0 | 0.0 | 0.1 |
| Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл | 1 229.9 | 872.7 | 2 327.3 | - | 0.0 | 0.0 | 0.0 |
| Эмнэлгийн багаж хэрэгсэл, нарийн хэмжүүр, хараа зүйн хэрэгсэл үйлдвэрлэл | 582.8 | 237.9 | 197.9 | - | 0.0 | 0.0 | 0.0 |
| Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл | 2 487.5 | 2 153.9 | 3 498.6 | - | 0.1 | 0.0 | 0.1 |
| Тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад | 1 155.0 | 1 487.0 | 2 004.9 | 15.1 | 0.0 | 0.0 | 0.0 |
| **Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж** | **373 429.1** | **408 754.7** | **454 226.6** | **-** | **8.4** | **7.3** | **7.5** |
| Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл | 340 022.0 | 369 312.9 | 412 107.1 | - | 7.6 | 6.6 | 6.8 |
| Ус ариутгал, усан хангамж | 33 407.0 | 39 441.7 | 42 119.5 | - | 0.7 | 0.7 | 0.7 |

Тайлбар: * Бүлгийн дүнд эзлэх хувь

Хавсралт № 27

**Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн, бүс, аймаг, нийслэлээр, жил бүрийн эцэст**

сая төг

| Аймаг, нийслэл | 2010 | 2011 | 2012 | Дүнд эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2010 | 2011 | 2012 |
| **Нийт дүн** | **4 468 170.3** | **5 626 746.2** | **6 058 023.8** | **100.0** | **100.0** | **100.0** |
| | | **Баруун бүс** | | | | |
| **Дүн** | **32 062.1** | **34 755.1** | **32 674.4** | **0.7** | **0.6** | **0.5** |
| БӨ | 7 566.7 | 7 947.9 | 7 617.3 | 0.2 | 0.1 | 0.1 |
| ГО | 6 155.1 | 5 584.2 | 6 285.5 | 0.1 | 0.1 | 0.1 |
| ЗА | 4 719.0 | 5 470.2 | 5 849.5 | 0.1 | 0.1 | 0.1 |
| УВ | 10 714.9 | 13 161.3 | 8 701.2 | 0.2 | 0.2 | 0.1 |
| ХО | 2 906.5 | 2 591.5 | 4 220.8 | 0.1 | 0.0 | 0.1 |
| | | **Хангайн бүс** | | | | |
| **Дүн** | **1 232 688.4** | **1 277 261.8** | **1 297 275.4** | **27.6** | **22.7** | **21.4** |
| АР | 4 929.2 | 2 715.1 | 5 506.9 | 0.1 | 0.0 | 0.1 |
| БХ | 6 708.5 | 4 276.5 | 4 859.4 | 0.2 | 0.1 | 0.1 |
| БУ | 3 503.2 | 8 251.6 | 9 399.9 | 0.1 | 0.1 | 0.2 |
| ОР | 1 208 343.6 | 1 248 919.7 | 1 262 421.6 | 27.0 | 22.2 | 20.8 |
| ӨВ | 4 632.0 | 7 380.7 | 11 442.1 | 0.1 | 0.1 | 0.2 |
| ХӨ | 4 571.8 | 5 718.1 | 3 645.5 | 0.1 | 0.1 | 0.1 |
| | | **Төвийн бүс** | | | | |
| **Дүн** | **718 037.9** | **1 033 785.0** | **1 019 338.5** | **16.1** | **18.4** | **16.8** |
| ГС | 25 890.8 | 24 648.1 | 26 928.2 | 0.6 | 0.4 | 0.4 |
| ДА | 109 039.9 | 102 504.6 | 146 213.8 | 2.4 | 1.8 | 2.4 |
| ДО | 3 267.4 | 3 705.7 | 18 377.7 | 0.1 | 0.1 | 0.3 |
| ДУ | 3 277.2 | 3 796.5 | 2 644.2 | 0.1 | 0.1 | 0.0 |
| ӨМ | 352 600.5 | 514 566.1 | 443 931.0 | 7.9 | 9.1 | 7.3 |
| СЭ | 215 087.2 | 367 841.9 | 347 543.2 | 4.8 | 6.5 | 5.7 |
| ТӨ | 8 874.9 | 16 722.1 | 33 700.5 | 0.2 | 0.3 | 0.6 |
| | | **Зүүн бүс** | | | | |
| **Дүн** | **115 415.5** | **112 799.2** | **162 004.2** | **2.6** | **2.0** | **2.8** |
| ДД | 7 636.2 | 10 559.8 | 16 064.7 | 0.2 | 0.2 | 0.3 |
| СҮ | 103 560.3 | 98 040.3 | 142 406.6 | 2.3 | 1.7 | 2.4 |
| ХЭ | 4 218.9 | 4 199.1 | 3 532.9 | 0.1 | 0.1 | 0.1 |
| | | **Улаанбаатар** | | | | |
| УБ | **2 369 966.4** | **3 168 145.0** | **3 546 731.4** | **53.0** | **56.3** | **58.5** |

# ХӨДӨӨ АЖ АХУЙН 2012 ОНЫ ТООЛЛОГЫН УРЬДЧИЛСАН ДҮН

Монгол Улсын “Статистикийн тухай” хуульд заасны дагуу манай улс “Хөдөө аж ахуйн тооллого”-ыг 2012 оны эхний хагас жилд багтаан улсын хэмжээнд амжилттай зохион байгуулж, дүнг нэгтгэн боловсруулаад байна.

Энэхүү тооллого нь манай улсын хувьд хөдөө аж ахуйн салбарт явуулж байгаа анхны тооллого бөгөөд хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний хэмжээ, бүтцэд гарч байгаа өөрчлөлтийг тооцон дүн шинжилгээ хийж, хөдөө аж ахуйн салбарыг цаашид хөгжүүлэх талаар бодлого боловсруулах, хэрэгжилтийг дүгнэхэд шаардагдах дэлгэрэнгүй мэдээллийг гарган авах, хөдөө аж ахуйн салбарт үйлдвэрлэгдсэн нийт бүтээгдэхүүний хэмжээг тооцох боломж бүрдүүлж байгаагаараа ихээхэн ач холбогдолтой юм.

Уг тооллогыг 2011 оны гүйцэтгэлд суурилан явуулсан бөгөөд манай улсын онцлог байдлыг харгалзан хэд хэдэн үе шаттайгаар зохион байгууллаа. Тооллогод мал аж ахуй, газар тариалангийн салбараас гадна эдийн засгийн үйл ажиллагааны нэгдсэн ангиллын дагуу ойн аж ахуй, ан агнуур, загасны аж ахуйн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй нэгжүүд мөн хамрагдсан. Түүнчлэн засаг, захиргааны нэгжийн хувьд бүх сумдын түвшинд холбогдох мэдээллийг цуглуулсан.

Тооллогод НҮБ-ын ХХААБ-ын зөвлөмжийн дагуу мэдээллийг цуглуулах нэлэнхүй ажиглалт болон түүвэр судалгааны аргыг хослуулан хэрэглэж, тооллогын үр дүнг газар зүйн мэдээллийн системтэй уялдуулж байгаагаараа энэ удаагийн тооллого онцлог юм.

Хөдөө аж ахуйн тооллогын хүрээнд нийтдээ 12 төрлийн асуулгын хуудсаар 500 орчим үзүүлэлтээр цуглуулсан.

## 1. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхэлсэн өрх, аж ахуйн нэгжийн тоо

ХАА-н тооллогод 2011 онд ХАА-н салбарт үйл ажиллагаа явуулсан 243.0 мянган өрх хамрагдсанаас 209.6 мянга буюу 86.2 хувь нь мал аж ахуй, 33.5 мянга буюу 13.8 хувь нь газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлсэн байна.

Түүнчлэн ХАА-н үйлдвэрлэл эрхэлсэн 2212 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсанаас 507 буюу 22.9 хувь нь мал аж ахуй, 1705 буюу 77.1 хувь нь газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлжээ.

ХАА-н тооллогод ойн аж ахуй эрхэлсэн 232, ан агнуурын аж ахуй эрхэлдэг 2, загасны аж ахуйн эрхэлдэг 9 аж ахуйн нэгж , байгууллага мөн хамрагдлаа.

**Хүснэгт 1. Хөдөө аж ахуй, ой, загас, ан агнуурын аж ахуй эрхэлсэн өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоо**

| | Бүгд | Өрх | ААНБ |
|---|---|---|---|
| Мал аж ахуй | 210070 | 209563 | 507 |
| Газар тариалан | 35166 | 33461 | 1705 |
| Ойн аж ахуй | 232 | - | 232 |
| Ан агнуурын аж ахуй | 2 | - | 2 |
| Загасны аж ахуй | 9 | - | 9 |

## Хөдөө аж ахуй, загас, ой, ан агнуурын салбарт ажиллагчдын тоо

ХАА, загас, ой, ан агнуурын үйл ажиллагааг эрхэлсэн өрх, аж ахуйн нэгж, байгууллагад нийтдээ 403.5 мянган байнгын ажиллагчид ажилласан бөгөөд үүний 84.9 хувь нь мал аж ахуйн салбарт, 14.5 хувь нь газар тариалангийн салбарт, үлдсэн 0.6 хувь нь загас, ой, ан агнуурын салбарт ажиллажээ.

**Хүснэгт 2. ХАА, загас, ой, ан агнуурын салбарт ажиллагчдын тоо, үйл ажиллагааны чиглэлээр**

мян.хүн

| | Ажиллагчдын тоо | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|
| **Бүгд** | **403.5** | **100.0** |
| Мал аж ахуй | 342.5 | 84.9 |
| Газар тариалан | 58.4 | 14.5 |
| Ойн аж ахуй | 2.5 | 0.6 |
| Ан агнуурын аж ахуй | 0.0 | 0.0 |
| Загасны аж ахуй | 0.1 | 0.0 |

## 2. Малын тоо, толгой

Мал тооллогын 2011 оны дүнгээр малын тоо 36.3 сая толгой болж, өмнөх оныхоос 11.0 хувь буюу 3.6 сая толгойгоор таван төрөл дээрээ өсжээ. Төрлөөр нь авч үзвэл адуу 2112.9 мянга, үхэр 2339.7 мянга, тэмээ 280.1 мянга, хонь 15668.5 мянга, ямаа 15934.6 мянга тоологдсон нь өмнөх оныхоос адуу 192.6 мянга, үхэр 163.7 мянга, тэмээ 10.5 мянга, хонь 1188.1 мянга, ямаа 2051.3 мянган толгойгоор тус тус өссөн байна.

ХАА-н тооллогын хүрээнд явуулсан түүвэр судалгааны дүнгээр 2012 оны хагас жилд малын тоо 46.9 сая толгойд хүрч, 2011 оны жилийн эцсийнхээс 10.6 сая толгойгоор буюу 29.0 хувиар өссөн дүн гарлаа. Төрлөөр нь авч үзвэл, адуу 322.2 мянга, үхэр 492.4 мянга, тэмээ 41.0 мянга, хонь 5110.6 мянга, ямаа 4589.0 мянган толгойгоор өсчээ.

**Хүснэгт 3. Малын тоо, 2011 оны жилийн эцэс, 2012 оны хагас жилийн байдлаар**

| Малын төрөл | 2011 оны жилийн эцэст, мян.тол | 2012 оны хагас жилд, мян.тол |
|---|---|---|
| **Бүгд** | **36335.8** | **46891.2** |
| Адуу | 2112.9 | 2435.1 |
| Үхэр | 2339.7 | 2832.1 |
| Тэмээ | 280.1 | 321.2 |
| Хонь | 15668.5 | 20779.1 |
| Ямаа | 15934.6 | 20523.6 |

2012 оны хагас жилийн малын тоо толгойн өсөлт үндсэндээ бог малын өсөлтөөр хангагдсан бөгөөд нийт өсөлтийн 48.4 хувийг хонь, 43.5 хувийг ямаа, 4.7 хувийг үхэр, 3.1 хувийг адуу, 0.4 хувийг тэмээний өсөлт хангасан байна.

## ХАА-н голлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл

### 3.1 Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Мал аж ахуйн салбарт 2011 онд нядалгааны жингээр 202.1 мян.т мах, 520.0 мян.т сүү, 19.0 мян.т хонины ноос, 5.5 мян.т ноолуур, 8.7 сая ширхэг арьс, шир үйлдвэрлэв.

Үйлдвэрлэсэн нийт махны 93.4 хувь, сүүний 98.7 хувь, ноосны 98.4 хувь, ноолуурын 99.4 хувь, арьс, ширны 97.4 хувийг тус тус өрхийн аж ахуйд үйлдвэрлэсэн байна.

Харин махны 6.6 хувь, сүүний 1.3 хувь, ноосны 1.6 хувь, ноолуурын 0.6 хувь, арьс, ширний 2.6 хувийг тус тус ААНБ-д үйлдвэрлэсэн байна.

### Хүснэгт 4. МАА-н голлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл

| | Бүгд | Өрх | ААНБ |
|---|---|---|---|
| Мах, нядалгааны жингээр, мян.т | 202.1 | 188.7 | 13.4 |
| Сүү, мян.т | 520.0 | 513.0 | 7.0 |
| Ноос, мян.т | 19.0 | 18.7 | 0.3 |
| Ноолуур, т | 5472.0 | 5440.2 | 31.8 |
| Арьс, шир, мян.шир | 8743.8 | 8517.0 | 226.8 |

Мал аж ахуй эрхэлсэн нэг өрх дунджаар, нядалгааны жингээр 900 кг мах, 2.5 мян.кг сүү, 89 кг ноос, 26.0 кг ноолуур, 40.6 ширхэг арьс, шир үйлдвэрлэсэн байна.

Харин мал аж ахуй эрхэлсэн нэг ААНБ дунджаар, нядалгааны жингээр 26.5 мян. кг мах, 13.7 мян.кг сүү, 592 кг ноос, 62.7 кг ноолуур, 447.3 ширхэг арьс, шир үйлдвэрлэжээ.

## 3.2 Газар тариалангийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Газар тариалангийн салбарт 2011 онд 457.2 мянган тонн үр тариа, 223.3 мянган тонн төмс, 109.6 мянган тонн хүнсний ногоо хурааж авсан байна.

Үр тарианы 9.5 хувь, төмсний 70.9 хувь, хүнсний ногооны 83.9 хувийг өрхийн аж ахуйд хурааж авсан байна. Харин үр тарианы 90.5 хувь, төмсний 29.1 хувь, хүнсний ногооны 16.1 хувийг аж ахуйн нэгж, байгууллагад хураан авчээ.

### Хүснэгт 5. Газар тариалангийн голлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл

| | Бүгд | Өрх | ААНБ |
|---|---|---|---|
| Үр тариа | 457.2 | 43.4 | 413.8 |
| Төмс | 223.3 | 158.4 | 65.0 |
| Хүнсний ногоо | 109.6 | 92.0 | 17.6 |

Газар тариалан эрхэлсэн нэг өрх дунджаар 1.3 тонн үр тариа, 4.7 тонн төмс, 2.8 тонн хүнсний ногоо үйлдвэрлэсэн байна. Харин газар тариалан эрхэлсэн нэг ААНБ 242.7 тонн үр тариа, 38.1 тонн төмс, 10.3 тонн хүнсний ногоо хураан авчээ.

## Газар тариалангийн салбарын зарим үндсэн үзүүлэлтүүд

ХАА-н тооллогоор ойн зурвасаар хүрээлж, хамгаалсан талбайн хэмжээ, усжуулалттай, тариалангийн талбайн хөрсний элэгдэл, эвдрэл, хүлэмжийн тариалалт зэргийн талаарх үзүүлэлтүүдийг цуглуулж, үр дүнг гаргалаа.

**Ойн зурвасаар хүрээлж, хамгаалсан талбай.** ХАА-н тооллогоор ойн зурвасаар хүрээлж, хамгаалсан 3.6 мянган га талбайтай 1.4 мянган өрх (1213), ААНБ (212) бүртгэгдлээ. Ойн зурвасаар хүрээлж, хамгаалсан талбайн 57.5 хувь нь өрхөд, үлдсэн 42.5 хувь нь ААНБ-д ногдож байна.

Нэг өрхөд дунджаар 1.7 га, аж ахуйн нэг нэгжид дунджаар 7.1 га ойн зурвасаар хүрээлж, хамгаалсан тариалангийн талбай ногдож байна.

**Усалгаатай талбай.** ХАА-н тооллогоор усалгаатай тариалан эрхэлсэн 28.0 мянган өрх, ААНБ бүртгэгдсэн бөгөөд үүний 27.1 мянга нь өрх, 906 нь ААНБ байна.

Усалгаатай тариалан эрхэлсэн өрх, ААНБ нь нийтдээ 49.6 мянга га тариалангийн талбайд усжуулалт хийсэн бөгөөд усалгаатай талбайн 42.3 хувь нь өрхөд, 57.7 хувь нь ААНБ-д байна.

Усалгаатай тариалан эрхэлсэн нэг өрхөд дунджаар 0.8 га, нэг ААНБ-д 31.6 га усалгаатай талбай ногдож байна.

**Хүлэмжийн аж ахуй.** ХАА-н тооллогоор 29.8 мянган га-д хүлэмжийн аж ахуй эрхэлсэн 2.2 мянган өрх, ААНБ бүртгэгдлээ. Үүний 2.3 мянга нь өрх, 0.2 мянга нь ААНБ байна.

Хүлэмжийн аж ахуй эрхэлсэн нэг өрхөд дунджаар 95.6 м2, нэг ААНБ-д 507.6 м2 хүлэмжийн талбай ногдож байна.

**Тариалангийн талбайн хөрсний элэгдэл, эвдрэл.** Тариалангийн талбайн хөрсний элэгдэл, эвдрэлийн талаарх мэдээллийг “элэгдэл, эвдрэлгүй”, “сул”, “дунд”, “хүчтэй ” гэсэн зэрэглэлээр газар тариалан эрхэлдэг өрх, ААНБ-аас цуглуулахад үр дүн дараах байдалтай гарлаа.

Өрхийн хувьд, газар тариаланг эрхэлсэн 33.4 мянган өрхийн 42.1 хувь нь тариалангийн талбайнхаа хөрсөнд ямар нэгэн элэгдэл, эвдрэлгүй гэж үзсэн бол 25.5 хувь нь сул, 30.4 хувь нь дунд , 2.0 хувь нь хүчтэй зэрэглэлд ангилжээ.

ААНБ-ын хувьд 1705 ААНБ-ын 34.0 хувь нь тариалангийн талбайнхаа хөрсөнд ямар нэгэн элэгдэл, эвдрэлгүй гэж үзсэн бол 26.6 хувь нь сул, 37.5 хувь нь дунд, 1.9 хувь нь хүчтэй зэрэглэлд ангилж үзсэн байна.

Газар тариалан эрхэлдэг өрх, ААНБ-ын талбайн хөрсөнд сул, дунд, хүчтэй зэрэглэлд багтах талбай багагүй жинтэй байна.

Газар тариалан эрхэлдэг өрх, аж ахуйн нэгж, байгууллага нь (тариалангийн газрыг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч) тариалангийн газрын хөрсний чанар байдлыг агрохимийн шинжилгээгээр хөрсний 0-40 см гүний ялзмаг, нитратын азот, хөдөлгөөнт фосфор, хөдөлгөөнт кали, хөрсний бүхэлшил, хөрсний эвдрэл, элэгдлийн зэрэг, усалгаатай тариалангийн газрын хөрсний намагжилт, давсжилт гэсэн үзүүлэлтүүдээр 5 жил тутам хийлгэх үүрэгтэй байдаг.

ХАА-н тооллогоор агрохимийн шинжилгээг газар тариалан эрхэлсэн өрхийн дөнгөж 3.8 хувь буюу 1.3 мянган өрх хийлгэжээ. Харин газар тариалан эрхэлсэн ААНБ-ын 33.8 хувь буюу 577 нь хийлгэсэн байна.

## 4. ХАА-н зориулалттай машин, тоног төхөөрөмж

ХАА-н тооллогоор ХАА эрхэлсэн өрхөд 66 төрлийн 217.4 мянган ширхэг ХАА-н зориулалттай машин, тоног төхөөрөмж бүртгэгдсэн бөгөөд үүнээс 99.1 хувь нь ашиглагдаж байна. Тэдгээрээс 0.2 хувийг бусдад түрээслүүлж, 0.7 хувь нь ашиглагдахгүй байна.

ХАА эрхэлсэн ААНБ-д мөн нийт 66 төрлийн 16.0 мянган ширхэг тоног төхөөрөмж бүртгэгдсэн бөгөөд үүний 98.8 хувийг ашиглаж байна. Эдгээрийн 0.1 хувийг бусдад түрээслүүлж, 1.1 хувь нь ашиглагдахгүй байна.

**Хүснэгт 6. ХАА-н зориулалттай машин, тоног төхөөрөмжийн тоо**

| | Бүгд | Өрх | | ААНБ | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Мал аж ахуй | Газар тариалан | Бүгд | Мал аж ахуй | Газар тариалан |
| Бүгд | 217424 | 187929 | 29495 | 16047 | 1904 | 14143 |
| Ашиглаж байгаа | 215536 | 186296 | 29240 | 15845 | 1858 | 13987 |
| Бусдад түрээслүүлсэн | 412 | 345 | 67 | 23 | 0 | 23 |
| Ашиглахгүй | 1476 | 1288 | 188 | 179 | 46 | 133 |

## 5. ХАА-н үйлдвэрлэлд үзүүлж буй үйлчилгээнд хамрагдсан байдал

ХАА-н тооллогоор манай улсын хөдөө аж ахуйн салбарын үндсэн үзүүлэлтүүдээс гадна энэ салбарт үзүүлж буй нийгмийн зарим төрлийн үйлчилгээ, хүртээмжтэй холбоотой үзүүлэлтүүдийг нэмэлт байдлаар цуглууллаа.

### 5.1 Эрсдлийн даатгалд хамрагдсан байдал

ХАА-н 2012 оны улсын тооллогод хамрагдсан ХАА эрхэлсэн нийт 243.0 мянган өрхийн 7.8 хувь буюу 19.0 мянган өрх нь эрсдлийн даатгалд хамрагдсан байна.

Салбараар, эзэмшлээр нь авч үзвэл, мал аж ахуй эрхэлдэг 209.6 мянган өрхийн 9.0 хувь буюу 19.0 мянган өрх, газар тариалан эрхэлдэг нийт 33.5 мянган өрхийн 500 орчим буюу 1.5 хувь нь эрсдлийн даатгалд хамрагдсан байна.

Түүнчлэн мал аж ахуй эрхлэгч 507 ААНБ-ын 8.3 хувь буюу 42 нь, газар тариалан эрхэлсэн 1705 ААНБ-ын 6.3 хувь нь буюу 107 нь эрсдлийн даатгалд хамрагджээ.

Үр дүн нь цаг уурын эрс, тэс уур амьсгалтай, байгаль цаг, уурын эрсдэлд байнга өртөх магадлалтай, сүүлийн жилүүдэд байгалийн бэрхшээлд олон удаа өртөж байсан манай орны хувьд ч ХАА-н эрхлэгч өрх, ААНБ-ын хувьд ч дээрх үзүүлэлт тун хангалтгүй байгааг харуулж байна.

**Хүснэгт 7. Даатгалд хамрагдсан, өрх, ААНБ-ын тоо, даатгалын төрлөөр, бүсээр**

| | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|
| | **Мал аж ахуй** | **Газар тариалан** | **Мал аж ахуй** | **Газар тариалан** |
| Өрх, ААНБ-ын тоо | 209563 | 33461 | 507 | 1705 |
| Даатгалд хамрагдсан өрхийн тоо | 18980 | 494 | 45 | 107 |
| Үүнээс: | | | | |
| Үрийн тариалангийн даатгалд | - | 100 | - | 30 |
| Малын индекжүүлсэн даатгал | 14387 | - | 28 | - |
| Арилжааны бусад даатгал | 3649 | 256 | 10 | 32 |
| Бусад | 944 | 138 | 4 | 45 |

Даатгалд хамрагдсан өрхийг салбараар авч үзвэл, даатгалд хамрагдсан мал аж ахуй эрхэлсэн өрхийн (давхардсан тоогоор) 77.6 хувь нь малын индексжүүлсэн даатгалд, газар тариалан эрхэлсэн өрхийн (давхардсан тоогоор) 51.8 хувь нь арилжааны даатгалд хамрагджээ.

ААНБ-ыг салбараар авч үзвэл, даатгалд хамрагдсан мал аж ахуй эрхэлсэн ААНБ-ын (давхардсан тоогоор) 66.7 хувь нь малын индексжүүлсэн даатгалд, газар тариалан эрхэлсэн ААНБ-ын (давхардсан тоогоор) 42.0 хувь нь арилжааны даатгалд хамрагджээ.

## 5.2 Санхүүгийн зээлд хамрагдсан байдал

Мал аж ахуй, газар тариалан эрхэлсэн нийт өрхийн 16.6 хувь буюу 40.4 мянга нь сүүлийн 5 жилд ХАА-н үйл ажиллагаандаа зориулан зээл авсан байна.

Түүнчлэн мал аж ахуй, газар тариалан эрхэлсэн ААНБ-ын 38.6 хувь буюу 0.9 мянга нь сүүлийн 5 жилд ХАА-н үйл ажиллагаандаа зориулан зээл авчээ.

Зээл авсан өрхийн тоо, авсан зээлийн тооноос харахад өрхийн хувьд мал аж ахуй эрхэлсэн өрхүүд нь зээлийн үйлчилгээнд илүү түлхүү хамрагдсан бол харин ААНБ-ын хувьд газар тариаланг эрхэлсэн ААНБ-ууд зээлийн үйлчилгээнд илүү түлхүү хамрагдсан байна.

**Хүснэгт 8. ХАА-н зориулалттай зээл авсан өрх, ААНБ-ын тоо авсан зээлийн тоо, зээлийн хугацаагаар**

| | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|
| | Мал аж ахуй | Газар тариалан | Мал аж ахуй | Газар тариалан |
| Зээл авсан өрх, ААНБ-ын тоо | 35197 | 5233 | 107 | 747 |
| Авсан зээлийн тоо | 77519 | 11732 | 199 | 1578 |
| үүнээс: 1 жилийн хугацаатай | 65281 | 9675 | 96 | 922 |
| 1-3 жил хугацаатай | 7483 | 1277 | 70 | 298 |
| 3 ба түүнээс дээш жилийн хугацаатай | 4755 | 780 | 33 | 358 |

Давхардсан тоогоор зээлд хамрагдсан ХАА-н үйлдвэрлэл эрхэлсэн өрх тутмын нэг нь богино хугацааны буюу 1 жил хүртэлх хугацаатай зээлийг сүүлийн 5 жилд 1.8 удаа, 1-3 жил хүртэлх хугацаатай зээлийг 4.7 өрх тутмын нэг нь, 3 ба түүнээс дээш жилийн хугацаатай зээлийг 7.4 өрх тутмын нэг нь авсан байна.

Давхардсан тоогоор зээлд хамрагдсан ХАА эрхэлсэн ААНБ тутмын нэг нь богино хугацааны буюу 1 жил хүртэлх хугацаатай зээлийг сүүлийн 5 жилд 1.8 удаа, 1-3 жил хүртэлх хугацаатай зээлийг 3.8 ААНБ тутмын нэг нь, 3 ба түүнээс дээш жилийн хугацаатай зээлийг 5.3 ААНБ тутмын нэг нь авсан байна.

Эндээс дүгнэхэд ХАА-н эрхэлсэн өрх, ААНБ-ууд нь үйл ажиллагаандаа зориулан богино хугацааны зээлийг олон удаагийн давтамжтайгаар авч, илүү түлхүү ашигладаг нь харагдаж байна.

Харин зээлийн хугацаа нь уртасах тусам зээлд хамрагдсан өрх, ААНБ-ын тоо багассан байна.

## 5.3 Санхүүгийн зээлийн гол эх үүсвэр, барьцаа хөрөнгө

ХАА эрхэлсэн өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хувьд зээл авсан үндсэн гол эх үүсвэр нь арилжааны банк болон төрийн байгууллага байна.

Өрхийн хувьд нийт зээлийн 93.0 хувийг арилжааны банкнаас, 5.4 хувийг төрийн байгууллагаас авсан бол, аж, ахуйн нэгж, байгууллагын хувьд нийт зээлийн 64.5 хувийг арилжааны банкнаас, 33.3 хувийг төрийн байгууллагаас авсан байна.

Зээл авсан өрхийн 83.4 хувь нь ХААН банкнаас, 9.3 хувь нь Хадгаламж банкнаас, 4.4 хувь нь Голомт банкнаас тус тус зээл авсан бол, харин ААНБ-ын 53.2 хувь нь ХААН банкнаас, 12.7 хувь нь Хас банкнаас, 12.1 хувь нь Голомт банкнаас тус тус зээл авсан байна. Арилжааны банкууд дундаас ХААН банк нь ХАА эрхэлдэг өрх, аж ахуй нэгжийн үйл ажиллагаандаа авах зээлийн гол эх үүсвэр болдог нь эндээс харагдаж байна.

**Хүснэгт 9. Хөрөнгө барьцаалж зээл авсан өрх, ААНБ-ын тоо, барьцаалсан хөрөнгийн төрлөөр**

| | Өрх | | ААНБ | |
|---|---|---|---|---|
| | Мал аж ахуй | Газар тариалан | Мал аж ахуй | Газар тариалан |
| Зээл авахдаа хөрөнгө барьцаалсан өрхийн тоо | 34200 | 4983 | 101 | 701 |
| Барьцаалсан хөрөнгө, өрхийн тоогоор | | | | |
| Мал | 32254 | 1921 | 44 | 127 |
| Газар | 4209 | 3240 | 39 | 448 |
| Машин, тоног төхөөрөмж | 9610 | 1800 | 43 | 383 |
| Бусад | 5324 | 1495 | 44 | 231 |

Зээл авсан өрхийн 96.9 хувь нь зээл авахдаа өөрийнхөө хөрөнгийг барьцаалсан байна. Барьцаалсан хөрөнгийг төрлөөр авч үзвэл, давхардсан тоогоор, 87.2 хувь нь мал, 29.1 хувь нь машин, тоног төхөөрөмж, 19.0 хувь нь газар, 17.4 хувь гэр, байшин зэрэг бусад хөрөнгийг барьцаалж зээл авсан байна.

Харин зээл авсан 845 ААНБ-ын 93.8 хувь нь зээл авахдаа хөрөнгө барьцаалсан байна. Барьцаалсан хөрөнгийг төрлөөр авч үзвэл, 60.5 хувь газар, 53.1 хувь нь машин, тоног төхөөрөмж, 34.3 хувь нь гэр, байшин зэрэг бусад хөрөнгө, 21.3 хувь нь мал барьцаалжээ. ХАА эрхэлдэг өрх, аж ахуй нэгж, байгууллагын хувьд зээлийн барьцааны гол хөрөнгө нь мал, газар, машин тоног төхөөрөмж болсон байна.

## 6. Малын ашиг шим

### 6.1 Малын сүүний гарц

Үнээний сүүний гарц. 2011 оны дөрвөн улирлын туршид түүвэр судалгааны дүнгээр нутгийн монгол үнээний сүүний өдрийн дундаж гарц 2.57 литр, сарлагийн үнээнийх 1.83 литр, цэвэр үүлдрийн үнээнийх 4.40 литр, эрлийз үнээнийх 3.72 литр байна.

Үнээний үүлдрээр харьцуулбал цэвэр үүлдрийн үнээний сүүний өдрийн дундаж гарц хамгийн их буюу сарлагийн үнээнийхээс 2.4 дахин, нутгийн монгол үнээнийхээс 71.2 хувиар, эрлийз үнээнийхээс 18.3 хувиар илүү байна.

### Хүснэгт 10. Үнээний сүүний өдрийн дундаж гарц, улирлаар

| Үүлдэр | Жилийн дундаж | үүнээс: | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Хавар | Зун | Намар | Өвөл |
| Нутгийн монгол үнээ | 2.57 | 2.45 | 3.13 | 2.52 | 1.91 |
| Сарлагийн үнээ | 1.83 | 1.53 | 2.16 | 1.91 | 1.48 |
| Цэвэр үүлдрийн үнээ | 4.40 | 3.75 | 5.90 | 4.33 | 2.95 |
| Эрлийз үнээ | 3.72 | 3.43 | 4.73 | 3.53 | 2.84 |

Нутгийн монгол үнээний сүүний жилийн дундаж гарц 519 литр, сарлагийн үнээнийх 371 литр, цэвэр үүлдрийн үнээнийх 1090 литр, эрлийз үнээнийх 966 литр байна.

Үнээнээс бусад төрлийн эх малын сүүний гарц. Гүүний сүүний өдрийн дундаж гарц 2.41 литр, ингэнийх 0.95 литр, эм хониных 0.27 литр, эм ямааных 0.31 литр байна.

### Хүснэгт 11. Үнээнээс бусад төрлийн эх малын сүүний өдрийн дундаж гарц, улирлаар

| Үүлдэр | Жилийн дундаж | үүнээс: | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Хавар | Зун | Намар | Өвөл |
| Гүү | 2.41 | - | 2.64 | 2.17 | - |
| Ингэ | 0.95 | 1.02 | 0.99 | 0.94 | 0.84 |
| Эм хонь | 0.27 | - | 0.27 | - | - |
| Эм ямаа | 0.31 | - | 0.38 | 0.20 | - |

Сүүний жилийн дундаж гарц гүүнийх 209 литр, ингэнийх 147 литр, эм хониных 17 литр, эм ямааных 29 литр байна.

## 6.2 Ноос, ноолуур, хөөвөр, хялгасын гарц

Жилд дунджаар өсвөр насны тэмээнээс 4.1 кг ноос, нас гүйцсэн тэмээнээс 5.1 кг ноос, хониноос 1.3 кг уртын ноос, 463 гр ахрын ноос, хурганаас 408 гр ноос тус тус хяргаж, ямаанаас 416 гр ноолуур самнаж, 239 гр хялгас, бод малаас 408 гр хөөвөр, 314 гр хялгас авдаг байна.

**Хүснэгт 12. Ноос, ноолуур, хөөвөр, хялгасын жилийн дундаж гарц**

| | Улсын дундаж |
|---|---|
| Тэмээний ноос, өсвөр нас | 4053 |
| Тэмээний ноос, нас гүйцсэн | 5050 |
| Хонины уртын ноос | 1279 |
| Хонины ахрын ноос | 463 |
| Хурганы ноос | 408 |
| Ноолуур | 416 |
| Ямааны хялгас | 239 |
| Бодын хөөвөр | 408 |
| Бодын хялгас | 314 |

## 7. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого, зардал

ХАА-н үйлдвэрлэлийн өртөг, зардлын судалгааны дүнгээр мал аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг нийт үйлдвэрлэлтэд 66.1 хувийг эзлэх болж, өмнөх судалгааны дүнгээс 9.9 пунктээр буурч, харин завсрын хэрэглээний эзлэх хувь 33.9 болсон байна.

Газар тариалангийн салбарын нэмэгдэл өртөг нийт үйлдвэрлэлтийн 45.4 хувийг эзэлж, өмнөх судалгааны дүнгээс 24.1 пунктээр буурсан байна.

Мал аж ахуй эрхэлдэг өрхийн аж ахуйн үйлдвэрлэлийн зардлын 9.5 хувийг тэжээл, 6.9 хувийг шатахуун, шатах тослох материал, 2.6 хувийг урсгал засварын зардал эзэлж байна.

Газар тариалангийн зардлын бүтцэд нэлээд өөрчлөлт орж, ихэнх зардлын төрлийн эзлэх хувь өссөн дүнтэй гарч энэ хэмжээгээр ашиг/алдагдал буурсан байна. Үрийн зардлын эзлэх хувь 17.2 болж өмнөх судалгааны дүнгээс 5.7 дахин, бордооных 2.4 хувь болж 4.8 дахин, шатахууных 11.1 хувь болж 85.0 хувиар тус тус нэмэгдсэн дүнтэй байна.

## Дэлхийн эдийн засаг, гадаад зах зээлийн тойм

### АНУ-ын эдийн засаг

АНУ-ын Эдийн засгийн шинжилгээний товчооны урьдчилсан тооцоогоор (2012 оны 12 дугаар сарын 20-нд мэдээлснээр) зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2012 оны 3 дугаар улиралд өмнөх улирлынхаас 3.1 хувиар* өсчээ[1].

Хэрэглээний үнийн индекс 2012 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас 0.3 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 1.8 хувиар өсчээ[2].

Гадаад худалдааны тэнцэл 2012 оны эхний 10 сард 452.5 тэрбум ам.долларын* алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 6.8 тэрбум ам.долл буюу 1.5 хувиар* буурчээ[3].

Тус улсын Холбооны нөөцийн сан (Төв банк)-гийн урьдчилсан тооцоогоор аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн индекс 2012 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас 1.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2.5 хувиар өссөн байна[4].

Ажилгүйдлийн түвшин 2012 оны 12 дугаар сард 7.8 хувь* болж, өмнөх сарынхтай ижил түвшинд** байна[2].

### Япон улсын эдийн засаг

Япон улсын Эдийн засаг, нийгмийн судалгааны институтийн урьдчилсан тооцоогоор (2012 оны 12 дугаар сарын 10-нд мэдээлснээр) зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн 2012 оны 3 дугаар улиралд өмнөх улирлынхаас 0.9 хувь*, өмнөх оны мөн үеийнхээс 3.5 хувиар буурчээ[5].

Хэрэглээний үнийн индекс 2012 оны 11 дүгээр сард 99.2 (2010=100) байгаа нь өмнөх сарынхаас 0.4 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 0.2 хувиар буурчээ[6].

Гадаад худалдааны тэнцэл 2012 оны эхний 11 сард урьдчилсан гүйцэтгэлээр 6285.8 тэрбум иений алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 3929.4 тэрбум иен буюу 2.7 дахин өсчээ[7].

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн индекс 2012 оны 11 дүгээр сард урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх сарынхаас 1.7 хувь*, өмнөх оны мөн үеийнхээс 5.8 хувиар буурчээ[8].

Ажилгүйдлийн түвшин 2012 оны 11 дүгээр сард 4.1 хувь* болж, өмнөх сарынхаас 0.1 пунктээр буурчээ[6].

## Европын холбооны гишүүн орнуудын эдийн засаг

Европын холбооны статистикийн байгууллагын урьдчилсан тооцоогоор (2012 оны 12 дугаар сарын 6-нд мэдээлснээр) тус холбооны гишүүн 27 орны зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн 2012 оны 3 дугаар улиралд өмнөх улирлынхаас 0.1 хувиар* өсч, өмнөх оны мөн үеийнхээс 0.4 хувиар* буурсан байна.

Инфляцийн түвшин 2012 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас 0.1 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 2.4 хувиар нэмэгдсэн байна.

Гадаад худалдааны тэнцэл 2012 оны эхний 10 сард 95.1 тэрбум еврогийн алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 58.1 тэрбум евро буюу 37.9 хувиар буурчээ.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн индекс 2012 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 1.0 хувь*, өмнөх оны мөн үеийнхээс 3.1 хувиар буурсан байна.

Ажилгүйдлийн түвшин 2012 оны 11 дүгээр сард урьдчилсан гүйцэтгэлээр 10.7 хувь болж, өмнөх сарынхтай ижил түвшинд, өмнөх оны мөн үеийнхээс 0.7 пунктээр өсчээ[9].

### ОХУ-ын эдийн засаг

ОХУ-ын Эдийн засаг, хөгжлийн яамны урьдчилсан тооцоогоор (2012 оны 12 дугаар сарын 27-нд мэдээлснээр) зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн 2012 оны эхний 11 сард өмнөх оны мөн үеийнхээс 3.5 хувиар өссөн байна[10].

Хэрэглээний үнийн индекс 2012 оны 12 дугаар сард өмнөх сарынхаас 0.5 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 6.6 хувиар нэмэгджээ.

Гадаад худалдааны тэнцэл 2012 оны эхний 10 сард 164.6 тэрбум ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 4.0 тэрбум ам.долл буюу 2.5 хувиар нэмэгдсэн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн индекс 2012 оны 11 дүгээр сард өмнөх сарынхаас 0.5 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 1.9 хувиар өсчээ.

Ажилгүйдлийн түвшин 2012 оны 11 дүгээр сард 5.4 хувь болж, өмнөх сарынхаас 0.1 пунктээр өсчээ[11].

***- Улирлын нөлөөллийг тооцсон***

****-АНУ-ын Хөдөлмөрийн яамны Хөдөлмөрийн Статистикийн товчооны 2013 оны 1-р сарын 4-нд мэдээлснээр***

## БНХАУ-ын эдийн засаг

БНХАУ-ын Үндэсний статистикийн товчооны урьдчилсан тооцоогоор (2012 оны 10 дугаар сарын 25-нд мэдээлснээр) зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн 2012 оны 3 дугаар улиралд өмнөх улирлынхаас 2.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 7.7 хувиар өссөн байна.

Хэрэглээний үнийн индекс 2012 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 2.0 хувиар өсчээ[12].

Гадаад худалдааны тэнцэл 2012 оны эхний 11 сард 199.5 тэрбум ам.долларын ашигтай гарчээ[13].

Аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөг 2012 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 10.1 хувиар өсчээ[12].

Зураг-1




## Зэсийн үнэ

Лондонгийн металлын биржид 1 тонн цэвэр зэсийн үнэ 2012 оны 12 дугаар сард дунджаар 7962.58 ам.долл болж, өмнөх сарынхаас 268.37 ам.долл буюу 3.5 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 395.03 ам.долл буюу 5.2 хувиар өсчээ[14] /Зураг 1/.

Зураг-2




## Алтны үнэ

Лондонгийн металлын биржид 1 унц алтны үнэ 2012 оны 12 дугаар сард дунджаар 1688.53 ам.долл болж, өмнөх сарынхаас 32.61 ам.долл буюу 1.9 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 36.22 ам.долл буюу 2.29 хувиар өсчээ[15] /Зураг 2/.

## Газрын тосны үнэ

Нью-Йоркийн худалдааны биржид 1 баррел газрын тосны үнэ 2012 оны 12 дугаар сард дунджаар 88.25 ам.долл болж, өмнөх сарынхаас 1.56 ам.долл буюу 1.8 хувиар өсч, өмнөх оны мөн үеийнхээс 9.97 ам.долл буюу 10.1 хувиар буурчээ[16] /Зураг 3/.

Зураг-3




## Хөрөнгийн биржийн индекс

АНУ-ын хөрөнгийн биржийн Аж үйлдвэрийн Dow Jones индекс 2012 оны 12 дугаар сард дунджаар 13144.18 нэгж болж, өмнөх сарынхаас 247.74 нэгж буюу 1.9 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 1068.49 нэгж буюу 8.8 хувиар нэмэгджээ[17].

Токиогийн хөрөнгийн биржийн Nikkei-225 индекс 2012 оны 12 дугаар сард дунджаар 9814.38 нэгж болж, өмнөх сарынхаас 754.52 нэгж буюу 8.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 1307.05 нэгж буюу15.4 хувиар нэмэгджээ[17].

Лондонгийн хөрөнгийн биржийн FTSE-100 индекс 2012 оны 12 дугаар сард дунджаар 5922.72 нэгж болж, өмнөх сарынхаас 135.20 нэгж буюу 2.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 442.63 нэгж буюу 8.1 хувиар нэмэгджээ[17].

***Эх үүсвэр:***

1. *http://bea.gov*
2. *http://stats.bls.gov*
3. *http://www.census.gov/foreign-trade*
4. *http://www.federalreserve.gov*
5. *http://www.esri.cao.go.jp*
6. *http://www.stat.go.jp*
7. *http://www.customs.go.jp*
8. *http://www.meti.go.jp*
9. *http://epp.eurostat.ec.europa.eu*
10. *http://www.economy.gov.ru*
11. *http://www.gks.ru*
12. *http://www.stats.gov.cn*
13. *http://www.mofcom.gov.cn*
14. *http://www.lme.com*
15. *http://www.lbma.org.uk*
16. *http://www.nymex.com*
17. *http://finance.yahoo.com*

**ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ИНДЕКС, сараар.**

нэгж

| Он | Аж үйлдвэрийн Dow Jones[1] | Nikkei-225[2] | FTSE-100[3] |
|---|---|---|---|
| 2011 I | 11802.37 | 10449.53 | 5971.59 |
| II | 12190.00 | 10622.27 | 6020.97 |
| III | 12081.48 | 9852.45 | 5856.92 |
| IV | 12434.88 | 9644.63 | 6007.86 |
| V | 12579.99 | 9650.78 | 5937.97 |
| VI | 12097.31 | 9541.53 | 5792.17 |
| VII | 12512.33 | 9996.68 | 5909.81 |
| VIII | 11326.62 | 9072.94 | 5271.31 |
| IX | 11175.45 | 8695.42 | 5228.49 |
| X | 11515.93 | 8733.56 | 5408.62 |
| XI | 11804.33 | 8506.11 | 5402.51 |
| XII | 12075.68 | 8507.32 | 5480.09 |
| 2011 I-XII | 11957.57 | 9429.30 | 5681.39 |
| 2012 I | 12550.89 | 8616.71 | 5694.45 |
| II | 12889.05 | 9242.33 | 5893.35 |
| III | 13079.47 | 9962.35 | 5875.40 |
| IV | 13030.75 | 9627.42 | 5725.58 |
| V | 12721.08 | 8842.54 | 5461.44 |
| VI | 12544.90 | 8638.08 | 5480.44 |
| VII | 12814.09 | 8760.68 | 5636.47 |
| VIII | 13135.12 | 8949.88 | 5796.95 |
| IX | 13418.50 | 8948.59 | 5805.44 |
| X | 13380.65 | 8827.39 | 5831.80 |
| XI | 12896.44 | 9059.86 | 5787.52 |
| XII | 13144.18 | 9814.38 | 5922.72 |
| 2012 I-XII | 12965.31 | 9102.56 | 5743.26 |

*Тайлбар:*

1. *АНУ-ын хөрөнгийн биржийн индекс*
2. *Токиогийн хөрөнгийн биржийн индекс*
3. *Лондонгийн хөрөнгийн биржийн индекс*

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороонд хэвлэв.

Хаяг :
14200 Улаанбаатар, Монгол Улс
Засгийн Газрын III байр, Өрөө-113
http://www.nso.mn
E-mail: information@nso.mn,
nso@magicnet.mn
Факс: (976-11) 329271
Утас: 322424, 326414